

УДИРТГАЛ

Зах зээлийн эдийн засгийн тогтолцооны тогтвортой байдал, хөгжлийн түвшинд түүний суурь харилцаанд голлон оролцогч ашгийн төлөө хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны тогтвортой байдал ихээхэн нөлөөлдөг. Ашгийн төлөө, бизнесийн үйл ажиллагаа явуулах бүтэц, зохион байгуулалтын олон төрөл, хэлбэр байдаг ч тэдгээрийн дотроос хамгийн өргөн хэрэглэгддэг нь компанийн бүтэц зохион байгуулалт билээ.

Манай улсын тухайд компанийн эрх зүйн зохицуулалт бий болгож улмаар ард иргэд маань компанийн бүтэц зохион байгуулалтын хэлбэрт тулгуурлан бизнесийн үйл ажиллагаа явуулж эхлээд төдий л удаагүй, бидний хуримтлуулсан туршлага ч зарим тохиолдолд хангалтгүй байгаагаас алдах эндэх нь их, компанийн бүтцийг үр дүнтэйгээр хэрэглэж чадахгүй байна.

Нөгөө талаас дэлхий дахинаа компанийн бүтэц зохион байгуулалт дан ганц эрх зүйн зохицуулалтаас хэдийнээ хальж өдрөөс өдөрт улам нарийсан өөрийн гэсэн нийтлэг зарчим, жишиг стандарттай болоод байгаа билээ. Тэдгээр зарчим, стандартууд нь нийтлэг эрх зүйн зохицуулалтаас гадна амьдралд үр дүнгээ нотолсон зан заншлын, ёс зүйн хэм хэмжээг агуулсан байдаг бөгөөд түүнийг “Компанийн засаглалын кодекс” буюу компанийн удирдлага, зохион байгуулалтын зарчмууд гэж томъёолж хэвшсэн байдаг.

Өнөөдрийн байдлаар дэлхийн улс орнууд төдийгүй олон улсын байгууллагуудын хэмжээнд 1999 онд анх баталж, улмаар 2004 онд нэмэлт, өөрчлөлт оруулаад байгаа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас баталсан “Компанийн засаглалын зарчмууд”-ыг нэгэн дуугаар хүлээн зөвшөөрөөд байна.

Монгол Улсын тухайд компанийн засаглалын талаар 2000 оны эхнээс түлхүү ярилцаж эхэлсэн бөгөөд компанийн засаглалыг манай улсад хөгжүүлэх нь компаниудын ялангуяа үнэт цаас нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг хувьцаат компаниудын удирдлага, зохион байгуулалтын тогтвортой бөгөөд зохистой ажиллагааны нөхцөлийг бүрдүүлж, улмаар хувьцаа эзэмшигчид болон компани хоорондын итгэлцэл хэвээр хадгалагдаж, тухайн компанийн хөрөнгө оруулалт татах чадвар өсөн нэмэгдэх ач холбогдолтой. Эдгээр нь улс орны нийгэм, эдийн засгийн макро түвшний тогтвортой байдал, өсөлтийг нөхцөлдүүлэх юм.

Тодруулбал, компанийн засаглалын кодекс нь хөрөнгө оруулагчид, санхүүжүүлэгчид, бизнесийн түншүүд, ажиллагсад зэрэг оролцогч талууд болон компанийн удирдлагын ашиг сонирхлын нэгдлийн зохистой харьцааг тогтоож, компанийн үйл ажиллагааг эрхлэн явуулах гадаад, дотоод таатай орчныг бий болгон, компанийн удирдлага болох төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны зохистой горимыг тогтоож өгдөг.

Дээр дурдсанчлан компанийн засаглалын хөгжил, үр дүнтэй байдал нь эрх зүйн зохицуулалтаас гадна компанийн зохистой засаглалын хэм хэмжээ тухайн нийгэмд төлөвшсөн, нийтлэг зан заншил, оролцогчдын мэдлэг чадвар, туршлага болон ухамсрын түвшин хэр өндөр байгаа зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг байна.

Иймээс энэхүү Монгол Улсын гэх Компанийн засаглалын кодексыг олон улсын хэмжээнд мөрдөж буй нийтлэг зарчим болох Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас баталсан “Компанийн засаглалын зарчмууд”, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудаас өгсөн

зөвлөмж, зөвлөгөө, дэлхийн бусад улс орны туршлага, өөрийн орны онцлог, бодит нөхцөл байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр боловсруулсан болно.

Энэхүү кодексыг хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг, нээлттэй буюу хувьцаат компанид тухайлан зориулж боловсруулсан бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компани болон бусад хуулийн этгээдийн тухайд өөрийн онцлогт тохируулан хэрэглэх боломжтой юм.

Энэхүү кодекс нь бүтцийн хувьд 9 бүлэг 41 зүйлээс бүрдэх бөгөөд агуулгын хувьд нийтлэгээр мөрдвөл зохих зарчмуудаас гадна зохих заавар, зөвлөмж, тэдгээрийн тайлбарыг багтаасан байгаа.

Манай улсын компани бүр компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа хэвшил болгож улмаар компанийн тогтвортой хөгжил, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэн, эдийн засгийн эргэлтийн хурд, хэр хэмжээ болон өсөлтийг ойрын ирээдүйд бодитой хэмжээгээр нэмэгдүүлэх болно.

---oO---

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧИМ

Компанийн засаглалын зарчмууд нь компанийн үйл ажиллагааг эрхлэн явуулах үндсэн зарчмуудыг тодорхойлох ба энэ нь түүний үйл ажиллагаанд оролцогч талуудын хууль ёсны ашиг сонирхол хийгээд эрхийг хүндэтгэх зарчимд суурилсан байх нь зүйтэй. Ялангуяа, компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх, ажлын байрыг шинээр бий болгох, компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах болон компанийн ашигт ажиллагааны түвшинг өсгөн нэмэгдүүлэх гэсэн оролцогчдын зүй ёсны ашиг сонирхолд нийцсэн байвал зохино. Энэхүү нөхцөлийг компанийн зохистой засаглалын зарчмууд бий болгодог.

Компанийн засаглалын зохистой бүтцийн үндэс суурь нь ил тод байдал, үр ашигтай зах зээл, хууль тогтоомжийг дээдлэх, удирдах, зохицуулах, хэрэгжүүлэх эрх мэдлийн үүрэг хариуцлагыг зааглан тогтоохыг хөхүүлэн дэмжихэд оршино.

Компанийн ашигт ажиллагааны түвшин болон хөрөнгө оруулалт татах чадварын гол үндэс нь түүний үйл ажиллагааг эрхлэн явуулахад оролцож буй оролцогчдын хоорондын итгэлцэл байдаг. Тиймээс энэхүү бүлэгт тусгасан зарчмууд нь компанийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл явц дах оролцогчид хоорондын итгэлцлийг бий болгоход чиглэсэн болно.

Компанийн засаглалын бүтцийг эдийн засагт үзүүлэх нөлөө, зах зээлийн чигч шударга байдал, зах зээлд оролцогсдын хувьд чухам ямар үр дүнтэй байх асуудлуудыг харгалзан үзсэний үндсэн дээр боловсруулсан.

Үүнээс гадна энэхүү бүлэгт тусгасан зарчмууд нь дараа дараагийн бүлэгт тусгасан зөвлөмжүүдийн үндэслэл болох ба энэхүү зарчмуудыг Компанийн тухай хууль болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн олон улсын байгууллагын /OECD/ 2004 онд шинэчлэн баталсан “Компанийн засаглалын зарчмууд”, дэлхийн бусад улс орнуудын, ялангуяа, шилжилтийн шатанд буй улс орнуудын туршлага, Европын сэргээн босголтын банк, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагаас ирүүлсэн зөвлөмжүүдэд тулгуурлан боловсруулсан.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Нэгдүгээр зүйл. Үндсэн ойлголт

Хувьцаа эзэмшигч нь оруулсан хөрөнгийнхөө хувь хэмжээгээр тухайн компанийн өмчийн тодорхой хувийг эзэмших эрхийг эдэлж мөн тэр хэмжээгээр хариуцлагыг хүлээдэг. Хувьцаа эзэмшигчдийн эрхийн асуудал нь компанийн засаглалын тогтолцооны нэг чухал үзүүлэлт тул тэдгээрийн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хувьцаа эзэмшигч нь тухайн компанийн хувьцааг худалдах, худалдан авах эсвэл бэлгэлэх, компанийн ашгаас ногдол ашиг хүртэх, компанийн талаар мэдээлэл авах болон хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал өгөх замаар компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх үндсэн эрхүүдийг эдэлнэ.

Хоёрдугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн эрх

Компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигч эрхээ хэрэгжүүлэх бодит боломжийг бүрдүүлсэн байна.

2.1. Хувьцаа эзэмшигчид нь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхээ шуурхай, баталгаатайгаар хянах боломжоор тэгш хангагдсан байхаас гадна өөрийн өмчлөл дэх хувьцааны өмчлөх эрхээ хууль тогтоомжид заасан журмын дагуу бусдад чөлөөтэй, шуурхай шилжүүлэх боломжтой байна.

2.2. Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох замаар компанийн удирдах үйл ажиллагаанд оролцох эрхээр хангагдсан байна. Үүний тулд дараах нөхцөлийг бүрдүүлсэн байвал зохино:

2.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам нь хувьцаа эзэмшигчид хуралд оролцох бэлтгэлээ хангах боломжийг бүрдүүлсэн байна.

2.2.2. Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны жагсаалттай танилцах боломжийг бүрдүүлсэн байна.

2.2.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах өдөр, цаг, байршлыг тогтоохдоо хувьцаа эзэмшигчид уг хувьцаа эзэмшигчдийн хуралд саадгүйгээр оролцох бодит боломжтой үеийг сонгосон байна.

2.2.4. Хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах, зарлахыг шаардах, хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах эрхээ хэрэгжүүлэхэд үндэслэлгүй саад бэрхшээлийг учруулдаггүй байна.

2.3. Нэгдмэл сонирхолтой этгээд буюу зохион байгуулалт бүхий хувьцаа эзэмшигчдийн эрхийг дараах байдлаар тодорхойлно.

2.3.1. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, зохион байгуулалт бүхий хувьцаа эзэмшигч нар нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцон санал өгч, бодлогоо тодорхойлдог, бодитоор санал өгдөг, энэхүү байдлаа олон нийтэд болон бусад хувьцаа эзэмшигч нарт мэдээлдэг байх шаардлагатай. Эдгээр хувьцаа эзэмшигч нар нь компанийн засаглалыг сайжруулах, түүнийг боловсронгуй болгох чиглэлээр дэмжлэг үзүүлж ажилладаг байна.

2.3.2. Нэгдмэл сонирхолтой этгээдүүд, зохион байгуулалт бүхий хувьцаа эзэмшигч нарын ашиг сонирхлын нэгдмэл байдал, зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэх бодлогыг тодорхойлж түүнийг олон нийтэд мэдээлдэг байна.

2.4. Хувьцаа эзэмшигчдийн дээрх эрхүүдээс гадна дараах эрхүүдийг эдэлнэ.

2.4.1. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн гишүүдийг сонгох, огцруулах эрхээр хангагдсан байна.

2.4.2. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ын гишүүд болон гүйцэтгэх удирдлагуудын цалин хөлс болон урамшууллын бодлогын асуудлаар байр сууриа илэрхийлэх боломжоор хангагдана.

2.4.3. Хувьцаа эзэмшигчид нь компанийн хэмжээнд хийгдэх дараах үндсэн өөрчлөлтүүдтэй холбогдсон шийдвэр гаргахад оролцох, тодорхой мэдээлэл авах эрхтэй байна. Үндсэн өөрчлөлт гэдэгт:

2.4.3.1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;

2.4.3.2. Хувьцаа нэмж гаргах зөвшөөрөл олгох;

2.4.3.3. Хөрөнгийг бүхэлд нь эсвэл компанийг худалдахад хүргэж болохуйц хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох.

2.5. Бүх хувьцаа эзэмшигчид, түүний дотор мэргэжлийн хөрөнгө оруулагчид эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

2.5.1. Мэргэжлийн хөрөнгө оруулагчид өөрсдийн компанийн засаглал болон санал өгөх бодлого мөн түүнчлэн санал өгөх эрхээ хэрхэн хэрэгжүүлэх журмаа ил тод нээлттэй болгосон байна.

2.5.2. Мэргэжлийн хөрөнгө оруулагчид нь тэдний хөрөнгө оруулалттай холбогдон үүсэх эрхээ хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмаа ил тод нээлттэй болгосон байна.

2.5.3. Хувьцаа эзэмшигчид болон мэргэжлийн хувьцаа эзэмшигчид энэхүү кодекст заасан үндсэн эрхээ урвуулан /хэтрүүлж ашиглах, буруугаар ашиглах, зарчимд заасан эрхээ зөрчих/ ашиглаж үгсэн хуйвалдахаас бусад зорилготой бол өөр хоорондоо харилцан зөвлөлдөх боломжтой байна.

Бусдын хөрөнгийг захиран зарцуулах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах эрх бүхий мэргэжлийн хөрөнгө оруулалтын байгууллага зохицуулалтын гадуур ямар нэгэн замаар компанийг худалдан авах эсвэл компанийн хяналтыг авах талтай байдаг. Түүгээр ч үл барам энэхүү хамтын ажиллагаа нь монополийн эсрэг хуулийн заалтыг тойрон гарах зорилгыг агуулж байх магадлалтай байдаг. Иймд:

2.5.3.1. Мэргэжлийн хөрөнгө оруулагчид компанийн стратегийн асуудлаар санал өгөхдөө зөвлөлдөж хамтран ажиллахад хязгаарлалт тавьж болно.

2.5.3.2. Хувьцаа эзэмшигчид мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд нарийн хяналт тавьдаг байна.

2.5.3.3. Хөрөнгө оруулагчид, мэргэжлийн хөрөнгө оруулагчдийн хамтын ажиллагааг ил тод байлгах ба зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэхийн тулд тодорхой хугацаанд арилжаанд оролцохгүй байх заалтыг ч тусгаж болно.

3 дугаар зүйл. Ногдол ашиг хүртэх эрх

Хувьцаа эзэмшигчид, хувь нийлүүлэгчид ногдол ашиг хуваарилах ажиллагаанд саадгүй хамрагдах, ногдол ашиг хүртэх эрхтэй байна. Үүний тулд дараах нөхцөлийг бүрдүүлсэн байвал зохино:

3.1 Ногдол ашгийн хэмжээг тогтоох болон тараах механизм нь хувьцаа эзэмшигчдэд ойлгомжтой, ил тод байна;

3.2 Хууль, компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт өөрөөр заагаагүй бол компанийн цэвэр ашгийг үнэн зөвөөр тодорхойлж үр ашгийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилдаг байна;

3.3 Ногдол ашиг тараах нөхцөл болон ногдол ашиг тараах журмын талаар хувьцаа эзэмшигчдэд хангалттай мэдээлэл өгдөг байна;

3.4 Ногдол ашиг хуваарилах шийдвэрийн үндэслэл болсон компанийн санхүүгийн байдал болон бусад мэдээлэл нь хувьцаа эзэмшигчдэд ил тод, ойлгомжтой байна;

3.5 Хувьцаа эзэмшигчид ногдол ашгаа авахад хүндрэл учрахааргүй байдлаар ногдол ашгийг тараана;

3.6 Ногдол ашгийг тараахаар тогтоосон хугацаанд багтаан хувьцаа эзэмшигчдэд бүрэн хуваарилж дуусах нөхцөлийг бүрдүүлсэн байна;

3.7 Ногдол ашгийг тараахаар тогтоосон хугацаанд бүрэн хуваарилж чадаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хүссэн үед ногдол ашгийг олгох боломжийг бүрдүүлсэн байна.

4 дүгээр зүйл. Компанийн тухай мэдээлэл авах эрх

Хувьцаа эзэмшигчид компанийн талаарх мэдээллийг тогтмол болон цаг тухай бүр шуурхай авах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Үүний тулд дараах нөхцөлийг бүрдүүлсэн байвал зохино:

4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл шатанд тухайн хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр шийдвэрлэх ач холбогдолтой бүхий л мэдээллийг **компанийн цахим хуудас, СЗХ, МХБ, мэргэжлийн байгууллагуудын цахим хуудсаар дамжуулж** хувьцаа эзэмшигчдэд өгсөн байна;

4.2. Тухайн жилийн компанийн үйл ажиллагааг дүгнэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх компанийн үйл ажиллагааны жилийн тайланд бүрэн тусгасан байна;

4.3 Компанийн тухай мэдээллээр хувьцаа эзэмшигчдийг тогтмол хангах үүрэг бүхий тухайлан томилсон ажилтан /цаашид “төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга” гэх/-тай, түүний үйл ажиллагааг хэвшүүлсэн байна.

4.4 Компанийн чухал ач холбогдол бүхий мэдээ, мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд цаг алдалгүй мэдээлдэг байх, үүнийг цахим хуудаст байршуулах буюу жилийн үйл ажиллагааны тайланд тусгах.

4.5 Хувьцаа эзэмшигчид нь олгогдсон эрхээ буруугаар ашиглахыг хориглоно. Хувьцаа эзэмшигчид нь бусад хувьцаа эзэмшигчид болон компанид хохирол учруулах зорилгоор аливаа үйлдэл, эс үйлдэл хийхийг хориглоно.

5 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн тэгш эрхийг хангах

Компанийн засаглалын тогтолцоо нь ижил төрлийн хувьцаа эзэмшигчдэд адил тэгш эрхийг эдлүүлнэ.

5.1. Компанид итгэх итгэлийг нэмэгдүүлэх нь компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдэд хэрхэн адил тэгш хандаж байгаагаас ихээхэн хамаардаг. Энэхүү зарчмыг дор дурдсан нөхцөлийг бүрдүүлснээр хангана:

5.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахдаа хуралд оролцогчдод саналаа хэлэх, сонирхсон асуултаа тавьж зохих хариултыг авах боломжийг тэнцүү олгосон байна;

5.1.2. Хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналаа саналын хуудсаар эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан саадгүй өгөх боломжтой байна;

5.1.3. Үнэт цаасны ханшинд нөлөөлж болох, үнэт цаасны арилжаанд оролцоход давуу тал олгох нийтэд тараагдаагүй мэдээлэл буюу дотоод мэдээллийг ашиглах боломжийг хаасан байна;

5.1.4. Хувьцаа эзэмшигчдийг нэр дэвшигчдийн талаар бүрэн мэдээллээр хангаж, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гишүүд болон гүйцэтгэх захирлыг сонгох ажиллагааг ил тод зохион байгуулна;

5.1.5. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанитай хийх аливаа хэлцэлд сонирхол бүхий гэж үзэж болох нөхцөл байдал илэрмэгц тэр талаар өөрсдөө заавал мэдээлдэг байна;

5.1.6. Компани болон хувьцаа эзэмшигчдийн хооронд эсхүл хувьцаа эзэмшигчдийн хооронд үүссэн аливаа зөрчил нь компанийн ашиг сонирхолд харшлахаар бол тэдгээр зөрчлийг зохистой хэлбэрээр зохицуулах шаардлагатай бүх арга хэмжээг авдаг байна.

5.2. **Хяналтын багц эзэмшигчид нь компаниас зүй бусаар ашиг хүртэх замаар компани болон жижиг хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулахаас хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн байна. Үүнд:**

5.2.1. **ТУЗ-ын гишүүд нь компани болон бүх хувьцаа эзэмшигчдийн сонирхолыг шудрагаар хамгаалах үүрэг хүлээнэ.**

5.2.2. **ТУЗ-ын гишүүдийг сонгох куммулятив аргыг хэрэглэнэ.**

5.2.3. **Хувьцаат компани компанийн хэлбэрээ өөрчилж үнэт цаасны бүртгэлээс хасуулах шийдвэр гаргах тохиолдолд хувьцааны хяналтын багц эзэмшигчид нь бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг хөндлөнгийн үнэлгээний байгууллагын тогтоосон үнэ эсвэл зохицуулалтын байгууллагын гаргасан дүрмийн дагуу худалдан авах үүрэг хүлээнэ.**

5.2.4. Компани нэмж хувьцаа гаргасан тохиолдолд бүх хувьцаа эзэмшигчид энэхүү хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээр хангагдана.

5.2.5. Жижиг хувьцаа эзэмшигчид эрхээ хамгаалах асуудлаар бусад хувьцаа эзэмшигчидтэй хамтран шүүхэд хандах эрхтэй байх бөгөөд энэ эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангагдсан байна.

5.3. Гадаад орноос болон зайнаас санал өгөх бүхий л боломжийг хангасан байх бөгөөд, хуулийн хүчин төгөлдөр байх нөхцөлийг бүрэн бүрдүүлэн саналын хуудсаар санал өгөх, мэдээллийн технологийн дэвшилт аргыг ашиглан санал өгөх боломжийг бүрдүүлсэн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

6 дугаар зүйл. Үндсэн ойлголт

Хувьцаа эзэмшигч нь тодорхой эрсдэл хүлээх замаар тухайн хөрөнгө оруулалт хийсэн компанийн хувьцааг өмчлөгч байдаг. Тэдгээрийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагаанд оролцох нь компанийн удирдах үйл ажиллагаанд оролцох, хөрөнгө оруулалтын эрсдэлээ бууруулах, хөрөнгө оруулсны төлөө хүртэх ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэх үндсэн чухал ач холбогдол бүхий боломж байдаг.

Тиймээс хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохистой хэлбэрээр, хувьцаа эзэмшигчдэд зардал, чирэгдэлгүй зохион байгуулж, компанийн үйл ажиллагааны төлөв байдлыг тодорхойлоход чухал ач холбогдол бүхий асуудлуудыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх замаар компанийн бодлогыг тодорхойлох бодит боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгохоос гадна компанийн санхүү, үйл ажиллагааны байдал, бизнес төлөвлөгөөний биелэлтийн талаар үнэн зөв, бодит, бүрэн мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд өгч ажилладаг байх нь зүйтэй юм.

Иймээс компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах ажиллагаа, журам нь энэхүү бүлэгт тусгасан зарчмуудыг бүрэн тусгасан, компанийн зүгээс хувьцаа эзэмшигч бүртэй тэгш хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байвал зохино. Ялангуяа, хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал нь жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьд компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагаас компанийн үйл ажиллагааны талаар сонирхсон асуултаа тавьж, тодорхой хариулт авах ганц боломж байдгийг анхаарах нь зүйтэй.

7 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах, мэдээлэл хүргэх

7.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэхдээ хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлтгэх боломжийг олгосон байна. Энэхүү зарчмыг дараах нөхцөлийг бүрдүүлэх замаар хангана:

7.1.1. Хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхдээ хувьцаа эзэмшигчид хурлаар хэлэлцэх асуудлуудын талаар холбогдох мэдээллийг хүлээн авч танилцах, тэдгээрийг сайтар судлах, хэлэлцэх асуудал тус бүрээр өөрийн байр суурийг тодорхойлох, хуралд оролцох эрх бүхий бусад этгээдүүдийн талаар мэдээлэл авах болон бусад хувьцаа эзэмшигчидтэйгээ зөвлөх боломж олгосон байна.

Энэхүү нөхцөлийг сайтар бүрдүүлэх нь хурлын үйл ажиллагааг шуурхай бөгөөд амжилттай явуулах, хурлаас үндэслэл бүхий шийдвэр гарах нөхцөлийг бүрдүүлнэ. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурал хуралдахаас 30-аас дээш хоногийн өмнө зарлах нь зүйтэй.

7.1.2. Хувьцаа эзэмшигчдэд хүргэх хувьцаа эзэмшигчдийн хурлын зард тухайн хувьцаа эзэмшигч хуралд оролцох хэлбэрээ сонгоход /биечлэн, саналын хуудсаар саналаа хүргэх, итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэн/ шаардлагатай мэдээллийг агуулсан байна.

7.1.3. Хууль, тогтоомжоор хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах мэдэгдэл гаргаснаас хойш хувь нийлүүлэгчдэд заавал танилцуулах бичиг баримтын жагсаалтыг тогтоож өгсөн байдаг. Эдгээр бичиг баримтад тусгасан мэдээлэл нь хувьцаа эзэмшигчдэд үндэслэл бүхий шийдвэр гаргах боломжийг олгохуйц байхаас гадна санал хураалт явуулах журмыг мөн багтаасан байвал зохино.

Мөн хувьцаа эзэмшигчид хурлаас гарах шийдвэрийн төсөл, дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах газар, санал өгөх хуудсыг хүлээн авч болох газар, хувьцаа эзэмшигчдийн санал авах, мэдээлэлтэй танилцах журмыг зөрчсөн тухай санал гомдлыг хүлээж авах этгээдийн тухай мэдээлэл, түүний харилцах утас, хаяг зэрэг мэдээллийг тусгасан байх нь зохистой. Эчнээ санал хураах тохиолдолд саналын хуудсыг хүлээн авах газар болон хүлээж авах сүүлчийн хугацааг тодорхой заасан байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, холбогдох мэдээллийг хүргэхдээ хуралд оролцох эрх бүхий бүх иргэн, хуулийн этгээдэд хүргэх шаардлагатай. Үүний тулд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарыг нийтэд хүргэхдээ тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүрээг харгалзан сонгохоос гадна хэд хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэгэн зэрэг хүргэх нь зүйтэй.

Үүнээс гадна, хуралд оролцох эрх бүхий этгээдүүдэд захидал, электрон шуудан, биечлэн хүргэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр давтан зарлах, нийтлэх зэрэг аль боломжит хувилбарыг нэмэлт ажиллагааны хувиар хэрэглэх нь зүйтэй. Өөр орон нутагт оршин суудаг хувьцаа эзэмшигчдийн тухайд тэдгээрт тухайлан зар хүргэх журмыг тогтоон мөрдвөл зохино.

Түүнчлэн, хурлын зар болон хуралтай холбоотой заавал танилцуулах баримт бичиг зэрэг шаардлагатай мэдээллийг хуралд оролцох эрх бүхий этгээдүүдэд холбоо харилцааны дэвшилтэт техник, хэрэгслийг ашиглах замаар /электрон шуудан гэх мэт/ тогтмол хүргэж хэвших нь зүйтэй.

7.2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий этгээдийн нэрсийн жагсаалттай танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэдээ олгох ёстой.

7.2.1 Хувьцаа эзэмшигч хуралд оролцох эрх бүхий бусад этгээдийн нэрсийн жагсаалттай танилцаж бусад хувьцаа эзэмшигчидтэй холбогдох, хурлаар хэлэлцэх гэж буй асуудлын талаар санал солилцох, өөрийн саналын хувилбарыг бэлтгэх боломжоор хангагдсан байна.

Компани нь хуралд оролцох эрх бүхий этгээдийн жагсаалтыг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэж эхэлсэн өдрөөс хурал хуралдах хүртэл, хэрвээ эчнээ санал хураалтаар асуудлыг шийдвэрлэх бол саналын хуудас хүлээн авах сүүлчийн мөч хүртэлх хугацаанд хувьцаа эзэмшигчдэд танилцах боломжоор хангана;

7.2.2 Сонирхсон этгээдэд хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалттай танилцах боломжийг олгохоос гадна тухайн этгээдийн нэр уг жагсаалтад байгаа эсэх талаарх тодорхойлолтыг гаргаж өгдөг байна. Энэ нь хувьцаа эзэмшигчид хуралд оролцох эрхээ баталгаажуулах, алдаа, зөрчил гарсан бол хурал хуралдахаас өмнө залруулах, улмаар хуралд саадгүй оролцох нөхцөлийг бүрдүүлнэ;

7.2.3 Хуралд оролцох эрх бүхий этгээдийн нэрсийн жагсаалттай танилцах ажиллагаа нь аль болох хувьцаа эзэмшигчдэд зардал, чирэгдэлгүй, шуурхай байна.

8 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдэд хурлын баримт бичгийг танилцуулах

8.1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулан тараасан бичиг баримт нь компанийн үйл ажиллагааны талаарх бүрэн мэдээллийг агуулсан байх бөгөөд хурлаар хэлэлцэх асуудлаар үндэслэл бүхий шийдвэр гаргах боломжийг хангасан байх ёстой.

8.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах явцад хувьцаа эзэмшигчдэд заавал танилцуулахаар хууль тогтоомжоор тогтоосон баримт, материалаас гадна тухайн компани нь өөрийн онцлогт тохируулан дүрэмдээ заах замаар заавал танилцуулах баримт, материалын жагсаалтыг баяжуулсан байна. Ялангуяа, компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх тохиолдолд өөрчлөн байгуулах болсон үндэслэл, өөрчлөн байгуулах төсөл, сүүлийн 3 жилийн

үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх тухай тооцооллын талаар зайлшгүй мэдээлдэг байх нь зүйтэй.

Энэ нь компанийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж улмаар хувьцаа эзэмшигчдийн итгэлийг бататган, боломжит хөрөнгө оруулагчдын тоог өсгөх ач холбогдолтой;

8.3 Хууль тогтоомж болон компанийн дүрэмд заасан баримт материалаас гадна шаардлагатай гэж үзвэл бусад баримтыг ТУЗ хувьцаа эзэмшигчдэд танилцуулах боломжийг дүрмээр олгосон, уг заалтын дагуу нэмэлт материалыг танилцуулдаг байвал зохино;

8.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал тус бүр дээр ТУЗ-ийн бичгээр гаргасан санал, тайлбарыг /хэрэв зарим гишүүд нь эсрэг саналтай байсан бол түүнийг тусгасан байна/ хувьцаа эзэмшигчдэд мөн заавал танилцуулж хэвших нь зүйтэй;

8.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт, материалыг ойлгомжтой, хэрэглэхэд энгийн хэлбэрээр, ач холбогдол, утга агуулга, цаг хугацааны дарааллыг харгалзан эмхтгэсэн байвал зохино. Биечлэн ирж танилцах боломжгүй хувьцаа эзэмшигчдэд холбогдох баримт, материалыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдахаас 20-оос доошгүй хоногийн өмнө, хаяг нь тодорхойгүй хувьцаа эзэмшигчдийн тухайд тэдгээрийн үйлчлүүлдэг үнэт цаасны мэргэжлийн байгууллагад хүргүүлсэн байна;

8.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдэд баримт, материалыг танилцуулах газар нь компанийн албан байр байхаас гадна, хувьцаа эзэмшигчдийн ихэнх нь очиход хялбар бөгөөд тохиромжтой цаг, газарт сонгоно;

8.7 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн эрх бүхий албан тушаалтныг сонгох тухай асуудлыг хэлэлцэх гэж буй нэр дэвшигчдийг сонгохоос өмнө тэдгээрээс тухайн албан тушаалд сонгогдохоос татгалзах зүйлгүй талаар бичгээр тодорхойлолт авах, бичгээр аваагүй бол заавал биечлэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж уг тодорхойлолтыг урьдчилан хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж байх нь зүйтэй;

8.8 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр гарах шийдвэрийн төслийг албан бичгийн шаардлагад нийцүүлэн утга агуулгын хувьд хоёрдмол санаагүй, тодорхой боловсруулахаас гадна асуудлыг нэг мөр цогцоор нь эцэслэн шийдвэрлэхэд шаардлагатай бүхий л шийдлийг тусган, уг асуудлыг хэн санаачилсан тухай тусгасан байна.

9 дүгээр зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах газар, тов болон хэлэлцэх асуудлын жагсаалт

9.1. Хувьцаа эзэмшигч хурал хуралдуулах болон хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад нэмэлт санал оруулах эрхээ ямар нэг үндэслэлгүй саад бэрхшээлгүйгээр хэрэгжүүлэх боломжтой байна.

Хувьцаа эзэмшигчид компанийн удирдах үйл ажиллагаанд оролцох эрхээ хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахыг шаардах, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд нэмэлт санал оруулах, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд хэн нэгний нэрийг дэвшүүлэх замаар идэвхтэй оролцдог.

Иймээс хувьцаа эзэмшигчдийн зүгээс дээрх ажиллагааг гүйцэтгэхэд тэдгээрийн эрхийн нотолгоог үнэт цаасны хадгаламж дахь бүртгэлд үндэслэх нь зүйтэй бөгөөд түүний бүртгэлтэй холбоотой баримтыг компани өөрөө хянах замаар хувьцаа эзэмшигчдээс эрхээ нотлох аливаа шаардлагагүй баримтыг шаарддаггүй байвал зохино.

9.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах газар, хугацааг сонгохдоо хувьцаа эзэмшигчид аль болох хүндрэлгүйгээр оролцох боломжийг бүрдүүлсэн байна.

Компанийн төв захиргаа хаана байрлаж буйгаас үл хамаарч хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн олонх нь аливаа зардал, чирэгдэлгүйгээр оролцох боломжтой газрыг сонгох нь зүйтэй.

Хувьцаа эзэмшигчид бүрэн багтахаар байранд хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахаас гадна хурал хуралдах өдрийг аль болох ажлын бус өдөр өглөө 09 цагаас оройн 22 цагийн хооронд зохион байгуулж байх нь зохимжтой.

10 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах

10.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын явцад уг хуралд оролцогч бүх хувьцаа эзэмшигч санал бодлоо илэрхийлж, өөрийн сонирхсон асуултаа тавьж, зохих хариултаа авах боломжийг бүрдүүлсэн байна.

10.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж буй асуудал тус бүрээр асуудлыг танилцуулах, хэлэлцэх хангалттай хугацаа олгосон байна.

10.3. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүд болон бусад эрх бүхий албан тушаалтнуудыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцуулж, тэдгээрээс компанийн үйл ажиллагааны талаар танилцуулга хийлгэн, хэлэлцэж буй асуудлаар санал, тайлбар хэлэх болон хувьцаа эзэмшигчдийн тавьсан асуултад бүрэн дүүрэн хариу өгөх нөхцөлийг хурлын дэгд тусгах замаар бүрдүүлсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох боломжгүй байгаа эрх бүхий албан тушаалтны нэр, шалтгааны талаар хурал даргалагч хувьцаа эзэмшигчдэд албан ёсоор танилцуулна.

Эрх бүхий албан тушаалтан нь тавьсан асуултад бүрэн дүүрэн хариулт өгөхийг эрмэлзэх ба тухайн үед хариулах боломжгүй бол бичгээр шуурхай хариу өгнө.

10.4. Хувьцаа эзэмшигчийн зүгээс хурлын дэг болон бусад дүрэм журамд заасан шаардлагыг зөрчсөнөөс бусад тохиолдолд хурал даргалагч нь хувьцаа эзэмшигчид үг хэлэх эрх олгохгүй байх, үгийг таслах, хэлсэн үгэнд зохисгүй тайлбар хийх замаар эрх мэдлээ урвуулан ашиглах боломжийг хаасан байна.

10.5. Эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцуулж хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт тавих, хариулт авах боломжийг бүрдүүлсэн байна.

11 дүгээр зүйл. Хувьцаа эзэмшигчдийг хуралд бүртгэх тухай

11.1 Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчийг бүртгэх ажиллагаа нь хувь нийлүүлэгчийн эрхийг хязгаарлахаар байж болохгүй. Үүний тулд:

11.1.1. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигч бүхэн ямар нэг шахалт, дарамт, хүндрэл бэрхшээлгүйгээр бүртгэлд хамрагдан хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох боломжийг хурал эхлэхээс өмнө олж авсан байхаар бүртгэлийн ажиллагааг зохион байгуулсан байвал зохино.

11.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулахгүй байх нөхцөлийн талаар урьдчилан компанийн дүрэмд тусгахаас гадна хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журамд тусган, хувьцаа эзэмшигчдэд хурлын зар хүргэх явцад оруулахгүй байх нөхцөлийн талаар албан ёсоор мэдэгддэг байвал зохино.

11.2. Хэт олон хувьцаа эзэмшигчидтэй компанийн тухайд бүртгэлийг хурал хуралдахаас өмнөх өдөр эхлүүлэх, эсхүл олон тооны бүртгэлийн ажилтан ажиллуулах замаар зохицуулж болно.

11.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хууль, дүрэмд заасан хугацаанд хуралдуулж, хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн баталгааг хангасан байна:

11.3.1. хувьцаа эзэмшигчдийн хурлыг аль болох нэг өдөрт багтаан явуулах нь зүйтэй;

11.3.2. хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг тоолох ажиллагаанд хяналтын тогтолцоог бий болгож, хяналт тавих ажиллагааны журмыг компанийн дүрэм, эсхүл бусад журамд тусгасан байна.

11.3.3. хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтын дүнг тухайн өдрийн хуралдаан дуусахаас өмнө гаргаж, хувьцаа эзэмшигчдэд танилцуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

12 дугаар зүйл. Үндсэн ойлголт

12.1. ТУЗ нь компанийн үйл ажиллагааны стратеги бодлогыг тодорхойлж, компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, компани болон хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээнэ.

Компанийг стратегийн удирдамжаар хангаж, компанийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, хувьцаа эзэмшигчдийн хүртэх ашгийг нэмэгдүүлэх үүрэг хүлээхийн зэрэгцээ ТУЗ нь ашиг сонирхлын зөрчил гарахаас сэргийлэх, компанийн өрсөлдөх чадварын тэнцвэрийг хангана. ТУЗ нь чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд хараат бус шийдвэр гаргах боломжтой байх шаардлагатай. ТУЗ-ын бас нэг чухал үүрэг бол компани холбогдох хууль тогтоомжуудыг, тухайлбал татвар, шударга өрсөлдөөн, хөдөлмөр, байгаль орчин, адил боломж, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны хуулиудыг даган мөрдүүлэх тогтолцоонд хяналт тавих асуудал юм.

Компани нь энэхүү бүлэгт заасан ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдэд тавих шаардлага, гишүүдийг сонгох журам, дахин нэр дэвших болзол, хараат бус гишүүний шалгуур, ТУЗ-ийн болон хороодын үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн хурлын зарыг хүргэх, хуралд оролцох, гишүүдийг мэдээллээр хангах журам, үүргээ зохих түвшинд хэрэгжүүлээгүй гишүүнд хүлээлгэх хариуцлага, гишүүдийн цалин урамшууллын бодлого зэрэг асуудлаар баримтлах зарчмаа ТУЗ-ийн үйл ажиллагааны журамдаа тусгаж, хувьцаа эзэмшигчдийн хурлаараа батлан мөрддөг байвал зохино.

13 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн үндсэн чиг үүрэг

13.1 ТУЗ нь компанийн үйл ажиллагааны стратеги бодлогыг тодорхойлж, уг бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тодорхой болгосон байна. Энэхүү зарчмыг дараах байдлаар хангана:

13.1.1 ТУЗ нь компанийн үйл ажиллагааны урт хугацааны бодлого, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлдог байх нь зүйтэй бөгөөд тэдгээрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд зах зээлийн нөхцөл байдал, компанийн санхүүгийн чадавх, бүтээгдэхүүний борлуулалтын түвшин, ажиллах хүчний чадавх зэрэг олон хүчин зүйлийг тогтмол харгалзан үздэг байх шаардлагатай.

13.1.2 ТУЗ нь компанийн үйл ажиллагааны бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг нэгдсэн журмаар, жилээр баталдаг байх нь зүйтэй. Компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт компанийн үйл ажиллагааны чиглэл тус бүрээр гүйцэтгэх ажил, түүний зардал, уг зардлыг бүрдүүлэх эх үүсвэр зэргийг нарийвчлан тогтоож өгсөн байх шаардлагатай.

13.1.3 ТУЗ-өөс нэгдсэн төлөвлөгөө батлахаас гадна үйлдвэрлэлийн үйл ажиллагааны, маркетингийн, хөрөнгө оруулалтын зэрэг нарийвчилсан төлөвлөгөөг баталж болно.

13.2. ТУЗ нь компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлдэг байна. Энэхүү зарчмыг дараах байдлаар хангана.

13.2.1. Компанийн хяналт нь ТУЗ-ийн удирдлага дор ажиллах замаар компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, компанийн санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн үнэн зөвийг тогтмол хянадаг байна.

13.2.2. Компанийн нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлангийн тогтолцооны нэгдмэл байдлыг хангах бөгөөд үүнд хөндлөнгийн аудит, үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлэх, эрсдэлийн менежмент, санхүү, үйл ажиллагааны хяналт шалгалт, хууль тогтоомж болон холбогдох стандартыг мөрдөж байгаа асуудал орно.

13.2.2.1. ТУЗ нь тайлан болон хяналтын тогтолцооны бодит нэгдлийг хангахын тулд компанийн хэмжээнд үүрэг, хариуцлагын тодорхой заагийг тогтоон мөрдүүлнэ.

13.2.3. ТУЗ-ийн гишүүд, удирдлага, хувьцаа эзэмшигчдийн хооронд гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчилд хяналт тавих бөгөөд үүнд компанийн хөрөнгийг зүй бусаар ашиглах, холбоотой талтай хэлцэл хийхдээ албан тушаалаа урвуулан ашиглаж, компанид хохирол учруулан ашиг хүртэх асуудал орно.

13.2.4. ТУЗ-ийн нэг чухал үүрэг бол санхүүгийн тайлан, компанийн хөрөнгийг ашиглах болон холбоотой талуудтай шударга бус хэлцэл хийх асуудлаас сэргэмжлэх зэргийг хамарсан дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, энэхүү тогтолцоо нь хэрхэн ажиллаж байгаад хяналт

тавих явдал юм. Энэ үүргийг ТУЗ-тэй шууд харилцах боломж бүхий дотоодын аудитын алба хэрэгжүүлнэ. Компанийн ажилтан, тухайлбал ерөнхий зөвлөх, энэ үүргийг хариуцан гүйцэтгэх тохиолдолд дотоод аудиторын нэг адил илтгэн тайлагнах үүрэг хүлээнэ.

13.2.5. ТУЗ нь хууль бус, ёс зүйгүй аливаа үйлдлийн талаар ТУЗ-д мэдээлдэг байх жишгийг хэвшүүлэхийг эрхэмлэнэ.

13.2.5.1. Мэдээлэл өгсөн ажилтныг хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлж компанийн хэмжээнд ёс зүйн кодексыг боловсруулан мөрдөж болно.

13.2.5.2. Компанид хохирол учруулж болох хууль бус, ёс зүйгүй үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авах үүрэг бүхий этгээдийг томилж болох ба энэ нь аудитын хороо эсвэл ёс зүйн хорооны аль нэг эсхүл хэд хэдэн гишүүн байж болно.

13.3. ТУЗ нь бусад сонирхогч талуудын ашиг сонирхлыг анхааран хамгаалах үүрэг хүлээх ба үүнд ажиллагсад, зээлдүүлэгчид, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид болон үйл ажиллагаа явуулж буй тухайн орон нутгийн иргэд хамрагдана. Үүнд хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны болон нийгмийн хариуцлагын стандартыг дагаж мөрдөх асуудал хамаарна.

13.4. ТУЗ-ийн гишүүд нь үнэн бодит мэдээлэлд тулгуурлан, чин үнэнчээр хичээнгүй, компанийн болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг удирдлага болгон ажиллана.

13.5. ТУЗ нь ёс зүйн өндөр стандартыг эрхэмлэн ажиллана. Мөн сонирхогч талуудын ашиг сонирхлыг анхаарч ажиллана.

ТУЗ-өөс дэвшүүлж байгаа зорилт тодорхой, хэрэгжих боломжтой байх үүднээс олон тооны компани өөрсдийн ёс зүйн кодексыг мэргэжлийн стандарт, зарим үед нийтээр хүлээн зөвшөөрсөн сахилга хариуцлагын ерөнхий хэм хэмжээнд тулгуурлан боловсруулдаг. Компани нь *\түүний салбаруудыг оролцуулан\ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн үндсэн эрхийн тухай Тунхаглалын үндсэн дөрвөн зарчмыг тусгасан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн олон улсын байгууллагын Үндэстэн дамнасан байгууллагуудын зарчмуудыг* сайн дурын үндсэн дээр хүлээн авч хэрэгжүүлж болох юм.

13.5.1. Компанийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа ёс зүйн кодекс нь янз бүрийн, ихэвчлэн бүлэглэл хооронд зөрчил үүсэх тохиолдолд шийдвэр гаргахдаа ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын баримтлах стандарт нь болно.

13.5.2. Ёс зүйн кодекс нь хувийн ашиг сонирхлын үүднээс асуудалд *\компанийн хувьцаатай холбогдсон асуудлыг оролцуулан\ хандах явдлыг хязгаарлах эрх зүйн үндэслэл болно. Өөрөөр хэлбэл ёс зүйн кодекс нь зөвхөн хууль тогтоомжоор тогтоосон хэм хэмжээнээс илүү өргөн хүрээтэй зохицуулалт болох зүйл юм.*

13.6. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод нээлттэй байдал болон харилцаа холбооны асуудалд хяналт тавина.

13.6.1. ТУЗ нь ТУЗ болон гүйцэтгэх удирдлага мэдээллийн нээлттэй байдал, хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудтай харилцааны асуудлаар ямар үүрэг, хариуцлага хүлээх асуудлыг зохицуулсан журам боловсруулан мөрдүүлэх үүрэгтэй.

13.6.2. Шаардлагатай тохиолдолд компани хөрөнгө оруулагчидтай харилцах харилцааг эрхлэх ажилтан томилон ажиллуулдаг байх ба тэрээр ажлаа шууд ТУЗ-д тайлагнадаг байвал зохино.

13.7. ТУЗ-ийн гишүүд нь хүлээсэн үүрэг хариуцлагадаа чин сэтгэлээсээ хандана.

13.7.1. Тухайн гишүүн нь хэтэрхий олон компанийн ТУЗ-ийн гишүүнээр нэг зэрэг ажиллах нь ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөх талтай тул компани нэг хүн хэдэн компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж болох эсэх талаарх шийдвэрийг гаргаж энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.

13.7.2. Тухайн гишүүн нь үүргээ зохих ёсоор биелүүлж чадаж байгаа эсэхийг ТУЗ-ийн гишүүн бүрийн хуралд оролцсон байдал *\хэдэн удаа хурал тасалсан гэх мэт\ ТУЗ-д ямар үүрэг гүйцэтгэж байгаа, ямар цалин урамшуулал авч байгаа зэргийг нийтэд мэдээлдэг байна.*

13.7.3. ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах үүднээс компаниуд ТУЗ-ийн гишүүдэд сургалт зохион байгуулах болон гишүүд үйл ажиллагаагаа өөрсдөө дүгнэх журам тогтоох зэрэг арга хэмжээг авч болно.

13.8. ТУЗ-ийн гишүүд болон дээд шатны гүйцэтгэх удирдлага нь компанийн гаргах гэж буй шийдвэрт ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ тухайгаа ТУЗ-д мэдэгдсэн байх ба уг

шийдвэрийг гаргахад оролцохгүй байх үүрэгтэй. Мөн түүнчлэн тайлангийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар жилийн үйл ажиллагааны тайланд заавал тусгаж хувьцаа эзэмшигчидэд мэдээлнэ.

13.9. ТУЗ нь үйл ажиллагааны тодорхой чиглэлээр ТУЗ-д зөвлөгөө үзүүлэх, түүний чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгөх зорилго бүхий дагнасан хороодтой байна.

14 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн хяналт

14.1 ТУЗ нь өөрийн чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэхэд эрсдэлийн шинжилгээг тогтмол гүйцэтгэдэг байх шаардлагатай бөгөөд эрсдэлийн үнэлгээ хийх, түүнийг тодорхойлох, эрсдэлийн эсрэг авах арга хэмжээг төлөвлөдөг тогтмол бүтэцтэй байх нь зүйтэй.

Ялангуяа, хүүгийн эрсдэл, даатгалын эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хууль зүйн эрсдэл, санхүүгийн хэрэгслийн болон эрхэлж буй үйл ажиллагаа тус бүрээр гарч болох эрсдэлийн шинжилгээг тогтмол хийдэг байх нь зүйтэй.

14.2. ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих замаар гүйцэтгэх удирдлагын үр дүнтэй үйл ажиллагааг хангадаг байна. Энэхүү зарчмыг дараах нөхцөлийг бүрдүүлснээр хангана:

14.3. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны үр дүнг холбогдох төлөвлөгөөнд үндэслэн хянахаас гадна шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлэх шийдвэрийг бие даан гаргаж, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг хэрэгжүүлэх эрхтэй байна.

14.4. Гүйцэтгэх удирдлагын мэдлэг, мэргэшил, чадварт тавигдах шаардлага, гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, урамшууллын журмыг компанийн дүрэмд тухайлан тусгах замаар гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, чадавхын тогтвортой байдлыг хангаж, үйл ажиллагаанд нь үнэлэлт өгөх боломжийг бий болгох нь зүйтэй бөгөөд уг шаардлага, гэрээний болон урамшууллын нөхцөлийн талаарх саналыг ТУЗ-өөс гаргадаг байх нь зүйтэй.

14.5. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалдаг байна. Үүний тулд дараах нөхцөлийг бүрдүүлсэн байна:

14.6. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны талаар болон бусад шаардлагатай мэдээллийг хүргэх үндсэн чиг үүрэг бүхий орон тооны ажилтантай /компанийн ТУЗ-ын нарийн бичгийн дарга/ байх ба хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журмыг тогтоон мөрдүүлж, биелэлтэд нь хяналт тавина;

14.7. ТУЗ нь хувьцаа эзэмшигчид болон компанийн бүтэц дэх нэгжүүдийн хооронд, эсхүл хувьцаа эзэмшигч хооронд гарч болох аливаа маргаан, сонирхлын зөрчлөөс сэргийлэх, гарсан тохиолдолд шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтоон мөрдүүлнэ;

14.8. ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын зүгээс хувьцаа эзэмшигчдэд мэдээллийг хэрхэн хүргэж байгаад хяналт тавина.

14.9. ТУЗ нь компанийн засаглалын зарчим, холбогдох бусад стандарт, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих ба шаардлагатай бол өөрчлөлт оруулна.

14.9.1. ТУЗ нь компанийн засаглалын зарчим, дүрэм журмын хяналтын хүрээнд компанийн дотоод бүтцэд байнга дүн шинжилгээ хийж, удирдлагын түвшинд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой зааглан тогтооно.

14.9.2. ТУЗ нь компанийн засаглалд байнгын хяналт тавьж, байдлыг тогтмол мэдээлж байхын зэрэгцээ ТУЗ болон ТУЗ-ын гишүүн бүр, гүйцэтгэх захирал болон бусад удирдлагууд үйл ажиллагаандаа өөрсдөө үнэлгээ өгдөг тогтолцоог бий болгоно.

15 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

15.1. ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь түүнд ногдуулсан чиг үүргийг үр дүнтэйгээр хэрэгжүүлж чадах хэмжээнд байна.

15.2. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд ажиллах гишүүдийн тоо нь хууль, дүрэмд заасан хэмжээнээс цөөнгүй, ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаа үр ашигтай, асуудлыг олон талаас нь хэлэлцэж, үндэслэл бүхий бодитой шийдвэрийг шуурхай гаргах хэмжээнд байна;

15.3. ТУЗ-ийн гишүүд хууль тогтоомж зөрчсөн, захиргааны зөрчил болон эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон, ялангуяа, бизнес, санхүү, татвар, үнэт цаасны чиглэлээр зөрчил дутагдал гаргасан бол уг гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгодог байна;

15.4. ТУЗ-ийн гишүүн нь компанийн эрх ашигт нийцүүлэн үйл ажиллагаа явуулах ба сонирхлын зөрчилтэй бол сайн дураараа эсхүл ТУЗ-ийн шийдвэрээр бүрэн эрхийг нь түдгэлзүүлдэг байна.

15.5. ТУЗ-ийн гишүүд нь хууль, дүрмээр тогтоосон үүргийг бүрэн дүүрэн гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, боловсрол, дадлага туршлагатай байх ба ТУЗ-ийн гишүүнд тавих шаардлагыг компанийн дүрмээр тусгайлан тогтоосон байвал зохино.

16 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний чиг үүрэг

ТУЗ-ийн бүрэлдэхүүнд хангалттай тооны хараат бус гишүүд орсон байна. **Хараат бус гишүүд нь ТУЗ-ын шийдвэр гаргах явцад ихээхэн нөлөөлж чадна. Тэдгээр хараат бус гишүүд нь ТУЗ-ын болон удирдлагын үйл ажиллагаанд үнэлгээ өгөхөд бие даасан хараат бус байдлаар байр сууриа илэрхийлдэг. Үүнээс гадна компанийн удирдлагын сонирхол нь хувьцаа эзэмшигчдийн сонирхолтой зөрчилдөх үед ТУЗ-ын хараат бус гишүүний үүрэг нэн чухал байдаг ба үүнд удирдлагын цалин урамшуулал, компанийн хяналтад өөрчлөлт оруулах, сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийх, санхүүгийн болон санхүүгийн бус тайлангийн нэгдмэл байдлыг баталгаажуулах зэрэг асуудлыг дурьдаж болно. Энэ чухал үүргийг хэрэгжүүлэх боломжоор хангах үүднээс хараат бус гишүүнийг сонгох шалгуурыг тодорхой тогтоон мэдээлэх нь зүйтэй.**

16.1. Санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд болон хувьцаат компанийн хувьд ТУЗ-ийн гишүүдийн 1/3-ээс доошгүй хувь нь хараат бус гишүүд байх нь зүйтэй.

16.2. Хараат бус гишүүдийн гол үүрэг бол компанийн гүйцэтгэх удирдлага, менежерүүдийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн зүгээс тавих хяналтыг үр ашигтай байлгах, компанийн удирдлага хувьцаа эзэмшигчдийн хооронд болон хувьцаа эзэмшигчдийн хооронд гарч болзошгүй сонирхлын зөрчлийг зөв зохистой, шударга шийдвэрлэх явдал бөгөөд хараат бус гишүүд нь компанийн гүйцэтгэх удирдлага, хяналтын багцыг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдээс хараат бус байж, шаардлагатай тохиолдолд тэдэнд бодитой зөвлөмж, зөвлөгөө өгч чаддаг байвал зохино.

16.3. ТУЗ-ийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах нэг зарчим нь гүйцэтгэх удирдлагын гишүүдээс ТУЗ-д байх тоог хязгаарлах, гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга нь нэг хүн байхыг хориглох явдал юм.

16.4. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь дор заасан шалгуурыг хангасан байна. Үүнд:

16.4.1. Компани болон толгой, охин, хараат компанид сүүлийн 3 жил ажиллаж байгаагүй, одоо ажилладаггүй;

16.4.2. Компанийн ТУЗ-ийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон хяналтын багц эзэмшигчийн нэгдмэл сонирхолтой этгээд, төрөл, садангийн холбоогүй;

16.4.3. Компанийн томоохон харилцагчийн хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан биш /нэг жилд тухайн харилцагчтай хийсэн хэлцлийн нийт дүн нь компанийн нийт активын 10-аас дээш хувьтай тэнцэж байвал томоохон харилцагч гэж үзнэ/.

Компанийн гүйцэтгэх удирдлага, хяналтын багц эзэмшигчдийн нэр дэвшүүлсэн ТУЗ-ийн гишүүд нь өөрийн үүргээ гүйцэтгэхдээ томилсон этгээдийнхээ нөлөөнд автан компанийн болон нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэн ажиллах зарчмыг алдагдуулах магадлалтай байдаг учир ТУЗ-ийн гишүүдийг тэдний аливаа нөлөөнөөс хараат бус байлгах үүднээс тэдгээрийг сонгохдоо аль болох олон хувьцаа эзэмшигчдийн саналыг харгалзан үзэх нь зүйтэй. Энэ зорилгоор ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэхдээ зөвхөн жижиг хувьцаа эзэмшигчдийн (тухайлбал, 10-аас доош хувийг эзэмшигч) саналаар нэр дэвшүүлж, сонгохдоо хувьцаа эзэмшигч бүр хувьцааны тооноос үл хамааран саналын 1 эрхтэй оролцож сонгох зарчмыг баримтлах нь зүйтэй. Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүнд хараат бус гишүүнийг багтаасан байвал зохино.

17 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн үүрэг хариуцлага

17.1. ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн болон ТУЗ-өөс байгуулагдсан хороодын хуралд тогтмол идэвхтэй оролцох замаар бүрэн эрхээ шаардлагын түвшинд хэрэгжүүлдэг байх ёстой.

17.2. ТУЗ-ийн гишүүд дараах шаардлагад нийцүүлэн ТУЗ-ийн хурлаа зохион байгуулна:

17.2.1. Тусгайлан гаргасан төлөвлөгөөний дагуу тогтмол хуралдна.

17.2.2. Гишүүн нь биечлэн эсвэл урьдчилан санал өгөх болон мэдээлэл харилцаа хэрэгсэл ашиглан хуралд оролцох боломжтой байна.

17.3. Тухайн жилийн ТУЗ-ийн нийт хурлын 1/3-ээс дээш хувьд хүндэтгэх шалтгаангүйгээр оролцоогүй гишүүнийг ТУЗ-д дахин сонгохгүй байх зарчмыг баримтална. Хүндэтгэх шалтгаан байсан ч урьдчилан санал өгөх, холбооны хэрэгслэл ашиглан оролцох гэх мэт бололцоотой аргаар хуралд оролцохыг гишүүд нь эрмэлздэг тогтолцоог бүрдүүлбэл зохино.

17.4. ТУЗ-ийн гишүүд нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хангалттай цаг зарж, бүрэн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргадаг байх ёстой.

17.4.1. Тодорхой асуудлаар шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээллийг ТУЗ-ийн гишүүд авдаг байх ёстой. Компанидаа албан тушаал эрхэлдэг гишүүдтэй болон компанийн гүйцэтгэх удирдлагын авч буй мэдээлэлтэй адил түвшний мэдээлэл авах, шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт, саналыг компанийн зардлаар гаргуулан авах боломжтой байна.

17.4.2. Хууль, компанийн дүрмээр тогтоосон үүргээ зохих түвшинд хариуцлагатай гүйцэтгэхийн тулд уг ажилдаа хангалттай цаг зарцуулах боломжтой байх ёстой. Үндсэн ажлын ачааллаа зөв тооцсон байхаас гадна олон компанийн ТУЗ-д сонгогдох нь үүргээ шаардлагын түвшинд хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болзошгүйг тооцоолсны үндсэн дээр нэрээ дэвшүүлдэг эсвэл дэвшүүлэх зөвшөөрөл олгодог, өөр компанийн ТУЗ-д сонгогдсон тухайгаа ТУЗ-д мэдээлдэг байх ёстой.

17.5. ТУЗ бүхэлдээ болон ТУЗ-ийн гишүүдийн хүлээх хариуцлага тодорхой байх ба энэ нь холбогдох дүрэм эсвэл журмаар зохицуулагдсан байна.

17.5.1. Ялангуяа ТУЗ-ийн гишүүдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан хохирлыг барагдуулах талаар журамд тусгасан байна.

17.5.2. Компанийн эд хөрөнгөд учруулсан хохирлын хэмжээг тогтоох аргачлалыг боловсруулан дүрэмд тусгасан байна.

17.6. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн гишүүдийг хариуцлагын даатгалд хамруулсан байвал зохино.

18 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын талаарх ерөнхий ойлголт

18.1. ТУЗ нь түүний чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх дагнасан хороодыг байгуулсны дараа тэдгээрийн эрх үүрэг, бүрэлдэхүүн, ажиллах журмыг тогтоож нийтэд мэдээлнэ. Энэ нь олон нийт, хөрөнгө оруулагчид ТУЗ-ийн хороодын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхөд чухал ач холбогдолтой юм. Ялангуяа хөндлөнгийн аудиторуудтай харилцаж байгаа харилцаанд хяналт тавихад чухал байдаг.

18.2. ТУЗ нь түүний дэргэд бие даан үйл ажиллагаа явуулах эрх бүхий хараат бус аудитын хороо, мөн нэр дэвшүүлэх болон урамшууллын хороодтой байж болно.

19 дүгээр зүйл. Нэр дэвшүүлэх хороо

19.1. ТУЗ-ийн гишүүдийг шударга зарчмаар сонгох зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулна. Уг хорооны нэр дэвшүүлэх үйл ажиллагааг шударга, хараат бус байхаар зохион байгуулна.

19.2. ТУЗ-д нэр дэвшүүлэх, сонгох үйл ажиллагааг хууль, журмын дагуу ил тод явуулна. Энэ нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчдийн оролцоог хөхүүлэн дэмжинэ.

19.2.1. Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшүүлэх, сонгохтой холбогдон гаргах асуудлыг зохицуулсан холбогдох журмын дагуу шийдвэрлэж түүний ил тод байдлыг хангах асуудлыг хариуцна.

19.3. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-д өндөр мэдлэг боловсролтой, ажлын туршлагатай, удирдан зохион байгуулах чадвартай, одоогийн ТУЗ-ийн ур чадварт шинэ эрч хүч өгөх замаар түүний үнэ цэнийг өсгөх чадавхтай нэр дэвшигчийг тодорхойлж санал оруулна.

19.4. Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигчийг өргөн хүрээнд нээлттэй зарлах замаар тодруулах нь зүйтэй.

19.5. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-д нэр дэвшүүлэх эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлэх тухай санал, нэр дэвшигчийн талаарх шаардлагатай мэдээллийг хүлээн авч тухайн этгээд нь хууль, тус кодекс, компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтоосон шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянаад, шалгуур хангахгүй байгаа бол энэ тухай нэр дэвшүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Хараат бус гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол хараат бус гэдгийг нотлох мэдээлэл, уг мэдээлэл үнэн зөв болох тухай нэр дэвшигчийн баталгаа зэргийг гаргуулсан байна. Эдгээр мэдээлэлд үндэслэн нэр дэвшигчийг саналын хуудсанд оруулах тухай саналаа ТУЗ-ийн хуралд оруулна.

19.6. ТУЗ-ийн гишүүн нас барсан, удаан хугацаагаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх хугацаагаар нөхөн сонгох гишүүний нэрийг дэвшүүлэх асуудлыг нэр дэвшүүлэх хороо хариуцан гүйцэтгэнэ.

19.7. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болсон үед тэдгээр гишүүд үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн тухай гишүүн тус бүрээр дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна. Уг танилцуулгад ТУЗ-ийн гишүүн бүр нийт хэдэн удаагийн хуралд оролцохоос хэдэн удаагийн хуралд оролцсон тухай мэдээлэл заавал байх ёстой.

19.8. Гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалд нэр дэвшүүлэх, тэдний талаар мэдээлэл бэлдэн ТУЗ-ийн хуралд оруулах, үүргийн гүйцэтгэлийн талаар дүгнэлт гаргах асуудлыг мөн нэр дэвшүүлэх хороо **холбогдох журмын дагуу ил тод, шудрага** хариуцан гүйцэтгэнэ.

20 дугаар зүйл. Цалин, урамшууллын хороо

20.1. Цалин, урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг боловсруулж, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулж ТУЗ-д оруулах үүрэгтэй байна.

21 дүгээр зүйл. Аудитын хороо

21.1. Компанийн дотоод хяналтын тогтолцоог удирдан, зохион байгуулах үүрэгтэй ТУЗ-ийн аудитын хороотой байна.

21.1.1. Хороо нь ТУЗ-ийн 3-аас доошгүй гишүүдээс бүрдэх бөгөөд Аудитын хорооны даргыг оролцуулаад бүрэлдэхүүнийх нь 2/3 нь хараат бус гишүүн, 1 гишүүн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй, тодорхой дадлага туршлагатай хүн байна.

21.1.2. Хороо нь компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд компанийн зүгээс тавих хяналтын үйл ажиллагаа болон компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж энэхүү үйл ажиллагааны үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-

ийн гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудитуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байна.

21.1.3. Хорооноос гаргаж буй саналууд нь зөвхөн зөвлөмж хэлбэртэй байна.

21.1.4. ТУЗ-ын аудитын хороо нь хөндлөнгийн аудитыг сонгож саналаа ТУЗ-д танилцуулна. ТУЗ түүнийг ХЭХ-д танилцуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

22 дугаар зүйл. Үндсэн ойлголт

Гүйцэтгэх удирдлагын үндсэн чиг үүрэг нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг тогтоосон төлөвлөгөөний дагуу эрхлэн явуулах ажиллагааг удирдлагаар хангах, хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-өөс гаргасан шийдвэр, дотоод аудитын алба /цаашид ДАА гэх/-наас гаргасан зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн, компанийн ашигт ажиллагааны түвшинг өсгөх замаар хувьцаа эзэмшигчдийн хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхэд оршдог.

Эдгээр чиг үүргийг амжилттай хэрэгжүүлж, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид болон компани хоорондын итгэлцлийг хадгалахад энэхүү бүлэгт тусгасан зарчим, зөвлөмжүүд чухал ач холбогдолтой.

23 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ

23.1. Компанийн гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ, хүрээг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулахтай холбоотой асуудлаар тодорхойлж, түүнийг өдөр тутмын ажиллагаанд тулгарах асуудлыг зохистой шийдвэрлэх чадвартай хувь хүн, эсхүл багаар бүрдүүлсэн байна.

23.1.1. компанийн өдөр тутмын үйл ажиллагаа гэдэгт компанийн өдөр тутам тогтмол байгуулдаг гэрээ хэлцэл, ажиллагаа хамаарах ба компанийн гүйцэтгэх удирдлагын бие даан шийдвэрлэж болох хөрөнгийн хэмжээг холбогдох дүрэм журамд заасан хувиас хэтрэхгүй байхаар хязгаарлан тогтоох нь зүйтэй бөгөөд уг хэмжээний хөрөнгийн асуудлыг холбогдох төлөвлөгөөнд туссан тохиолдолд шийдвэрлэх эрхтэй байх нь зүйтэй. Компанийн холбогдох төлөвлөгөөнд тусаагүй, эсхүл компанийн өөрийн хөрөнгийн тогтоосон хязгаараас дээш хэмжээний хөрөнгийн талаар аливаа захиран зарцуулах шийдвэрийг ТУЗ шийдвэрлэдэг байвал зохино:

23.1.2. Гүйцэтгэх удирдлагыг багаар гүйцэтгүүлэх нь зүйтэй бөгөөд энэ нь түүний шийдвэрийн оновчтой байх нөхцөлийг бүрдүүлнэ.

23.2. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн санхүү, эдийн засгийн төлөвлөгөөний дагуу ажиллана.

23.2.1 Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-аас баталсан компанийн санхүү, эдийн засгийн болон бусад төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг явуулах үүрэгтэй;

23.2.2 Гүйцэтгэх удирдлага нь төлөвлөгдөөгүй аливаа гэрээ, хэлцэл, ажиллагаа явуулах шийдвэрээ заавал ТУЗ-тэй зөвшилцөж, зөвшөөрөл авсны үндсэн дээр гүйцэтгэдэг байна. Энэ талаар холбогдох журмыг компанийн дотоод дүрэм журамд тусгасан байна.

24 дүгээр зүйл. Гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүн

24.1. Гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүн дэх хувь хүмүүс нь гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх чадвар, боломжоор хангагдсан, үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

24.1.1 Гүйцэтгэх удирдлагад ажиллах хувь хүн, багийн гишүүд нь тухайн компанийн үйл ажиллагаа явуулж буй салбар, чиглэлээр мэргэжлийн мэдлэг, дадлага туршлагатай байвал зохино.

24.1.2 Гүйцэтгэх удирдлагад ажиллах хувь хүн, багийн гишүүд өмнө зөрчил дутагдал, гэмт хэрэг үйлдэж байгаагүй, сонирхлын зөрчилгүй, өрсөлдөх аливаа нэг компанитай холбоогүй, өөрийн мэдлэг, чадвараа компанийн ашиг сонирхлын төлөө зориулж, тогтвортой ажиллах боломж, хүсэл эрмэлзэлтэй байвал зохино.

24.1.3 Гүйцэтгэх удирдлага нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх мэдээ, мэдээлэл, баримт материалтай саадгүй танилцах, холбогдох мэдээллийг цаг тухай бүр авах боломжоор хангагдсан байна.

24.1.4 Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигч нь томилогдохоосоо өмнө түүнд нөлөөлж болох, түүний үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулж болох бүх мэдээлэлтэй ТУЗ-өөр дамжуулан танилцаж ажиллах боломжтой талаараа мэдэгдэл өгсөн байх нь зүйтэй.

24.1.5 Гүйцэтгэх удирдлагад ажиллах хувь хүн, багтай байгуулах гэрээнд гүйцэтгэх удирдлагын ажлын зорилт, зорилго, хүлээгдэж буй үр дүн, урамшууллын хэмжээ, олгох журам, хүлээх хариуцлага, түүний эрх хэмжээг түдгэлзүүлэх, эгүүлэн татах үндэслэл, журам болон гүйцэтгэх удирдлага өөрийн үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээ, мэдээллийг гаргах хуваарь, хүргэх нэгж, албан тушаалтны талаар тодорхой тусгасан байна.

25 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага, урамшуулал

25.1. Гүйцэтгэх удирдлага нь компанийн эрх ашигт нийцүүлэн зохистой ажиллах үүрэгтэй. Үүний тулд өөрөөс шалтгаалах анхаарал, зүтгэлийг гаргаж, боломжит алдагдлаас сэргийлэх бүхий л боломжтой арга хэмжээг авч ажилладаг байх нь зүйтэй.

25.2. Гүйцэтгэх удирдлага компанийн эрх ашигт нийцүүлэн ажиллахад саад, бэрхшээл учруулж болох нөхцөл байдал үүсэхээс сэргийлж, тийм байдал үүсгэхгүй ажиллах үүрэгтэй.

25.3. Компанийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, нөхцөл шаардлагад чанд нийцүүлэн явуулахаас гадна компанид гарч болох аливаа зөрчил, маргааныг зохистой хэлбэрээр шуурхай шийдвэрлэж ажиллах үүрэгтэй. Хууль тогтоомж зөрчсөн ажиллагааг цаг тухай бүр таслан зогсоох арга хэмжээг авахаас гадна их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчил бүхий хэлцэл болон компанийн хэтийн үйл ажиллагаанд гарч болох ноцтой үр дагавар бүхий асуудлаар аливаа бие даасан шийдвэр гаргахыг хориглоно.

25.4. Гүйцэтгэх удирдлага нь хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн компанийн талаарх аливаа мэдээ, мэдээлэл, эрх хэмжээгээ ашиглаж болохгүй.

25.5. Үйл ажиллагаандаа хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлоос гадна компанийн оролцогч бусад талууд болох зээлдүүлэгчид, бизнесийн түншүүд, ажилчид болон төрийн ашиг сонирхлыг харгалзан ажиллана.

25.6. Гүйцэтгэх удирдлага нь компанийн хэвийн ажиллагааг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг шуурхай авах үүрэгтэй. Ялангуяа, ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх талаар анхаарч ажиллах нь зүйтэй.

25.7. Гүйцэтгэх удирдлагын буруутай үйл ажиллагааны улмаас компани болон хамт олон, хувьцаа эзэмшигчдэд учирсан хохирлыг гүйцэтгэх удирдлага хувийн өмчөөс барагдуулах тухай заалтыг түүнтэй байгуулах гэрээнд тусгахаас гадна түүний үйл ажиллагааны зохистой байсан эсэх, компанид хохирол учруулсан эсэх асуудлаар шүүхэд хандах эрхийг хэрэгжүүлдэг байх нь зүйтэй. Нөгөө талаас гүйцэтгэх удирдлагыг өөрийнх нь хөрөнгөөр хариуцлагын даатгалд хамруулах арга хэмжээ ч авч болно.

25.8. Зохисгүй ажиллагаа явуулсан, компанид хохирол учруулсан гүйцэтгэх удирдлагыг дахин удирдах албан тушаалд ажиллуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

25.9. Гүйцэтгэх удирдлагад олгох шагнал, урамшууллыг тодорхойлохдоо түүний чадвар, компанид оруулсан бодит хувь нэмрийг харгалздаг байх нь зүйтэй.

ТАВДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

26 дугаар зүйл. Үндсэн ойлголт

Хувьцаа эзэмшигчид болон сонирхсон бусад талуудад компанийн талаарх үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэх нь компани болон хувьцаа эзэмшигчдийн хоорондын итгэлцлийг хадгалах, нэмэлт хөрөнгө оруулагчдыг бий болгохоос гадна хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийн удирдлагад оролцох эрхээ зохистойгоор хэрэгжүүлэх, улмаар компанийн үйл ажиллагааны тогтворжиж, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр оновчтой гарах үндсийг бүрдүүлдэг.

Компани нь хууль, зохицуулах байгууллагаас тогтоосон дүрэм журамд заасан болон бусад чухал ач холбогдол бүхий мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг зохицуулахын тулд холбогдох журмыг ТУЗ-өөрөө батлан мөрдүүлдэг байх нь зүйтэй.

27 дугаар зүйл. Мэдээллийн ил тод байдал

27.1. Мэдээллийг нээлттэй, ил тод болгох үйл ажиллагаанд дараах зарчмыг баримталбал зохино. Үүнд:

27.1.1. Тогтмол байх;

27.1.2. Цаг хугацаандаа байх;

27.1.3. Компанийн хувьцаа эзэмшигчид болон сонирхогч бусад этгээдэд бүгдэд нь тэгш хүртээмжтэй байх;

27.1.4. Үнэн зөв, тодорхой, ойлгомжтой байх;

27.1.5. Агуулгын хувьд хоёрдмол санаагүй, бүрэн дүүрэн байх;

27.1.6. Компанийн бизнесийн эрх ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангасан байх;

27.1.7. Хувьцаа эзэмшигчид мэдвэл зохих өөрийн үйл ажиллагааны доголдол, дутагдлыг нууж хаахгүй байх.

27.2. Компаниас нийтэд хүргэх мэдээллийн жагсаалт, нийтэд хүргэх арга хэрэгсэл /нэвтрүүлэх, нийтлүүлэх мэдээллийн хэрэгслэл, давтамж/, хариуцах албан тушаалтан зэргийг тогтоосон байна. Нийтэд хүргэх мэдээллийг компанийн вэб сайтад давхар байршуулж хэдийд ч саадгүй авах боломжоор хангасан байх нь зүйтэй.

27.3. Мэдээллийг нээлттэй, ил тод болгохдоо нууц, дотоод мэдээллийг хууль бусаар, компанийн ашиг сонирхлын эсрэг ашиглах явдлаас сэргийлсэн байна.

27.4. Мэдээллийг нээлттэй, ил тод болгох ажиллагааг гүйцэтгэх удирдлага эрхлэн явуулах бөгөөд түүний ажиллагаанд ТУЗ тогтмол хяналт тавьж ажилладаг байна.

27.5. Компани нь хууль, зохицуулах байгууллагаас баталсан дүрэм журмаар тогтоосон мэдээллээс гадна хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын зүгээс шийдвэр гаргахад нөлөөлөх бүх мэдээллийг нээлттэй байлгана.

27.6. Компанийн хүний нөөцийн бодлого нь ил тод байна. Тухайлбал хүний нөөцийн хөгжил, сургалт, ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллуулах хөтөлбөрүүд, ажиллагсдын хувьцаа эзэмших төлөвлөгөө зэрэг нь компанийн өрсөлдөх чадварын давуу талыг зах зээлийн оролцогсдод мэдээлэх чухал ач холбогдолтой.

28 дугаар зүйл. Нийтэд хүргэх мэдээлэл

28.1. Компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдад үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардлагатай, компанийн санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлтүүд, өмч хөрөнгийн болон удирдлагын бүтэц зохион байгуулалт

зэрэгтэй холбоотой үнэн зөв мэдээллийг цаг тухай бүрд нь нийтэд мэдээлдэг байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

28.1.1. Ижил төрлийн мэдээллийг хувьцаа эзэмшигчид нь олж авах, танилцах боломжоор тэгш хангагдсан байна.

28.2. Компани нь мэдээллээ нийтэд саадгүйгээр, хурдан хүргэх боломжийг бүрэн дүүрэн бүрдүүлэх бодлого, чиг хандлага бүхий байна.

28.3. Хувьцаа эзэмшигчид нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, компанийн удирдлага, томоохон хувьцаа эзэмшигчдийн тухай болон компанийн санхүүгийн байдал, хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц нөхцөл байдал, үйл явдлын талаар үнэн зөв, бүрэн бөгөөд бодит мэдээллийг цаг тухай бүрд нь шуурхай олж авах боломжоор хангагдсан байна.

28.4. Компани нь өөрийн дотоод буюу нууц мэдээллийн ашиглалтад хяналт тавьдаг байна.

28.5. Хууль тогтоомж, дүрэм журмаар тогтоосон мэдээллээс гадна дор дурьдсан мэдээллийг нийтэд хүргэдэг байвал зохино:

28.5.1. Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын талаарх болон мөн уг мэдээллийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл;

28.5.2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тухай мэдээлэл;

28.5.3. Нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн нэр /тэдгээр этгээд нь компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол/;

28.5.4. Нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тухай мэдээлэл;

28.5.5. Компанийн томоохон зээлдүүлэгчид, харилцагчдын тухай мэдээлэл;

28.5.6. Компанийн хараат, охин компанийн тухай мэдээлэл;

28.5.7. Компанийн халаасны хувьцааны тухай мэдээлэл;

28.5.8. Компанийн нэр, төв захиргааны оршин байх газар өөрчлөгдсөн тухай мэдээлэл;

28.5.9. Компанийн салбар, төлөөлөгчийн газрын тухай мэдээлэл;

28.5.10. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд гарсан өөрчлөлтийн тухай мэдээлэл;

28.5.11. Компанийн аудиторыг сонгон гэрээ байгуулсан, өөрчилсөн;

28.5.12. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийн тухай;

28.5.13. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /дүрмийн сан/ -г нэмэгдүүлэх, хорогдуулах төслийг ТУЗ баталсан;

28.5.14. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан тухай;

28.5.15. Их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг ТУЗ юмуу хуульд заасан тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал баталсан тухай;

28.5.16. Компанийн үл хөдлөх хөрөнгийн 10-ээс дээш хувийг худалдсан, барьцаалсан, ямар нэг хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл;

28.5.17. Компанийн үйл ажиллагаа, хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн;

28.5.18. Төрийн болон орон нутгийн өмчлөлд байсан компанийн хувьцааны хяналтын багц хувьд шилжсэн;

28.5.19. Компанийг хуульд заасан хэлбэрээр өөрчлөн байгуулах төслийг ТУЗ баталсан;

28.5.20. Нийтэд санал болгон шинээр болон нэмж үнэт цаас гаргах төслийг ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан тухай мэдээлэл;

28.5.21. Компанийн санхүүгийн тайлан, төрийн зохицуулалтын байгууллагаас тогтоосон нэмэлт, тайлбар тодруулгын хамт;

28.5.22. Компанийн үл хөдлөх хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийлгэсэн тухай тайлан;

28.5.23. Компанийн борлуулалтын орлогын 10-аас дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, лицензийг худалдсан, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай;

28.5.24. Компанийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсэж болох эрсдэлийн тухай мэдээлэл.

28.6. Нийтэд хүргэх мэдээллийг нягтлан бодох бүртгэл, санхүү, санхүүгийн бус стандартын хэм хэмжээнд мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэнэ.

Стандартыг мөрдлөг болгох нь хөрөнгө оруулагчдын зүгээс компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, тайлангийн үнэн зөв байдал, харьцуулалт хийх боломжийг олгодог бөгөөд компанийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, хөрөнгө оруулалтын шийдвэрээ үндэслэлтэй гаргахад чухал байдаг.

29 дүгээр зүйл. Тайлангийн ил тод байдал

29.1. Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан нь дараах мэдээллүүдийг агуулсан байна:

29.1.1. Компанийн зорилго, үйл ажиллагааны стратеги;

29.1.2. Санхүүгийн байдал ба үйл ажиллагааны үр дүн;

29.1.3. Хувьцаа эзэмшигчдийн статус болон хувьцаа эзэмшигчид эрх, үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн талаарх статистик тоо баримт;

29.1.4. Хөрөнгийн нэмэгдсэн байдал ба санхүүгийн жилд гарсан капиталжих зардал;

29.1.5. Бизнесийн орчин ба эрсдэлийн хүчин зүйлүүд;

29.1.6. Компанийн удирдлагад ажиллагсдын талаарх мэдээлэл;

29.1.7. ТУЗ-ийн дарга, гишүүд, аудиторуд болон гүйцэтгэх удирдлагуудын шагнал урамшуулал;

29.1.8. Хараат бус аудиторуд, рейтингийн байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын үнэлгээний тайлан;

29.1.9. Мэдээллийг нээлттэй болгох талаар хууль, зохицуулах байгууллагын журмын дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн эсэх, хэрэгжүүлээгүй бол хүлээсэн хариуцлага;

29.1.10. Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлан;

29.1.11. Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд нь эрх бүхий байгууллагаас баталсан компанийн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх эсвэл тайлбарлах үүрэг хүлээх ба үүнийг Хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлийн журамд шаардлага болгон тусгасан байх ёстой;

29.1.12. Тухайн компанийн засаглалын тогтолцоо нь энэхүү кодекст заасан зарчмаас ялгаатай байгаа болон энэхүү кодекст заасан зарчмыг хэрэгжүүлээгүй, дагаж мөрдөөгүй шалтгаан үндэслэл;

29.1.13. Ирэх онд Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөө.

30 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ил тод байдал

30.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өмнө дараах мэдээллийг хувь нийлүүлэгчдэд заавал танилцуулна. Үүнд:

30.1.1. Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан;

30.1.2. Жилийн санхүүгийн тайлан холбогдох тайлбар, тодруулга, аудитын байгууллагын дүгнэлтийн хамт;

30.1.3. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол үндэслэл;

30.1.4. Хянан шалгах зөвлөлийн тайлан;

30.1.5. Төлөөлөн удирдах болон хянан шалгах зөвлөлд нэр дэвшигчдийн тухай танилцуулга;

30.1.6. Хэрвээ ээлжит хурлаар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцэх бол нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, үндэслэл, тайлбарын хамт, компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх бол өөрчлөн байгуулах хэлбэр, үндэслэл, өөрчлөн байгуулах журам, үүнтэй холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам зэргийг тусгасан өөрчлөн байгуулах төсөл, бусад холбогдох баримт бичиг;

30.1.7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бусад асуудлыг хэлэлцэхэд хувьцаа эзэмшигчдэд ямар бичиг баримт танилцуулахыг компанийн холбогдох журамд тусгасан байна.

30.2. Хууль, зохицуулах байгууллагын журам, энэхүү кодекс болон компанийн дүрмээр тогтоосон мэдээллийг нээлттэй болгохоос гадна хувьцаа эзэмшигчдийн хүссэн мэдээллийг цаг тухайд нь саадгүй гаргаж өгөх ёстой.

30.3. Компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг нэгдмэл сонирхолтой эзэмшиж байгаа этгээд нь компанийн нягтлан бодох бүртгэлийн болон гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэлтэй танилцах холбогдох мэдээллийг авах эрхтэй байна.

30.4. Хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр компанийн мэдээллийг гаргаж өгөх нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг байна. Мэдээлэл хүсэж байгаа хувьцаа эзэмшигч хүсэлтдээ өөрийн болон эцэг /эх/ -ийн нэр, хаяг /оршин суух, шуудангийн болон электрон/, холбоо барих утас, эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл, авахыг хүсэж байгаа мэдээлэл, мэдээлэл авах хэлбэр /биечлэн, бичгээр, электрон шуудангаар/ зэргийг заасан байвал зохино.

30.5. Мэдээлэл авах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор /мэдээлэл ач холбогдлоо алдахаар бол боломжит богино хугацаанд/ ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан мэдээллийг боломжит хэлбэрээр хүргүүлдэг байхаар журамлах нь зүйтэй. Хувьцаа эзэмшигчийн хүссэн мэдээлэл нь хууль тогтоомж болон компанийн дотоод бичиг баримтаар тогтоосон нээлттэй болгох мэдээллийн жагсаалтад багтаагүй бөгөөд компанийн бизнесийн нууцад хамаарахаар мэдээлэл бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг хүргүүлдэг байх шаардлагатай.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ОРОЛЦОГЧ ТАЛУУД

31 дүгээр зүйл. Үндсэн ойлголт

Банк, санхүүгийн байгууллага болон бусад зээлдүүлэгч, даатгагч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч зэрэг компанийн бизнесийн түншүүд, ажиллагсад болон тэдний төлөөний байгууллага, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд нь компанийн үйл ажиллагаанд оролцогч талууд болно.

Эдгээр талууд нь компанийн хэвийн бөгөөд цаашдын үйл ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлдэг тул тэдгээрийн эрхийг хууль тогтоомж, дүрэм журам, гэрээнд заасны дагуу чанд хамгаалж, харилцан ашигтай байх зарчмыг баримтлан хамтарч ажиллах нь зүйтэй.

Компани нь ажиллагсад, зээлдүүлэгчид, нийлүүлэгчид, хэрэглэгчид болон нийгмийн бусад төлөөлөл зэрэг оролцогч талуудтай олон талт, төрөл бүрийн харилцаанд орж байдаг. Үүнээс гадна эдгээр оролцогч талууд нь компанийн үйл ажиллагааг цаашид хөгжин дэвжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймээс оролцогч талуудтай урт хугацаанд тогтвортой хамтран ажиллах нь компанид ихээхэн өгөөжтэй, ашигтай байдаг тул холбогдох хууль журам, тэдэнтэй байгуулсан гэрээний дагуу оролцогч талуудын эрхийг хамгаалах асуудлыг нэн тэргүүнд тавьж ажиллах нь зүйтэй.

31.1. Компанийн засаглалын тогтолцоо нь зээлдүүлэгчид, компанийн ажиллагсад зэрэг оролцогч талуудын хууль тогтоомжид заасан эрхийг хүндэтгэн, компанийн зээлжих чадвар, хөрөнгө оруулалтыг татах чадвар, хувьцаа болон бусад үнэт цаасны үнэ цэнийг өсгөх, шинэ ажлын байрны тоог нэмэгдүүлэх зорилгыг хангасан байна.

31.2. Компанийн үйл ажиллагааны үр ашигтай байдлыг хангахын тулд гүйцэтгэх удирдлага нь гуравдагч талууд болох зээлдүүлэгчид, бизнесийн түншүүд, төрийн хийгээд тухайн компани болон түүний охин, хараат компани, салбар, төлөөлөгчийн газар оршин байгаа орон нутгийн засаг захиргааны байгууллагын сонирхлыг харгалзан үздэг байна.

31.3. Компанийн үйл ажиллагааны өгөөжийг дээшлүүлэхийн тулд компанийн удирдлага нь ажиллагсдын ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулна.

31.4. Компанийн ажилчид нь удирдлагын хууль зөрчсөн болон ёс зүйгүй, компанийн зорилгод үл нийцэх үйл ажиллагааны талаарх үнэн бодит мэдээллийг компанийн хяналтын зөвлөл, ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо, хувьцаа эзэмшигч, харилцагчдад мэдээлдэг байх бөгөөд энэ үйлдлийнх нь төлөө түүнд удирдлагын зүгээс шийтгэл ногдуулдаггүй байна.

32 дугаар зүйл. Оролцогч талуудын эрх

32.1. Хууль журам болон гэрээнд заасан нөхцөлийн дагуу оролцогч талуудын эрхийг хамгаалах ёстой.

32.2. Зээлдүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд нөлөөлж болох компани нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, дүрмийн сангаа багасгах зэрэг асуудлуудыг шийдвэрлэхдээ зээлдүүлэгчийн эрхийг хамгаалах арга замыг тодорхой болгосон байх ёстой.

32.2.1. Компани тэргүүн ээлжид зээлдүүлэгчийн төлбөрийг барагдуулах бөгөөд зээлээ буцаан төлөх боломжид нөлөөлөхүйц үйл явдлын талаар зээлдүүлэгчид цаг тухайд нь мэдэгдэх үүрэгтэй.

32.2.2. Компанийн бонд эзэмшигчид оруулсан хөрөнгийнхөө эргэн төлөлттэй холбогдон гарах эрсдэлийг хүлээхээр байвал холбогдох журмын дагуу хамгаалагдсан байна.

32.3. Компани нь хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл шаардлагыг чанд мөрдөж ажиллах бүхий л боломжит арга хэмжээг бүрэн авсан байна. Үүнд:

32.3.1. Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид заасны дагуу ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөлд анхаарч, хууль, хөдөлмөр хамгааллын журамд заасан хөдөлмөрийн нөхцөлийг хангасан байна.

32.3.2. Ажиллагсад тогтвортой ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд хүчин чармайлт гаргах ёстой. Ажиллагсад нь энэ асуудалд өөрсдийн зүгээс хариуцлагатай хандах ёстой.

32.3.3. Компани ажиллагсдын зөвлөл гэх мэт тэдний ашиг сонирхлыг төлөөлөх байгууллага байхыг дэмжих нь зүйтэй. Хөдөлмөрийн нөхцөл, ажиллагсдын нийгмийн болон цалин урамшууллын асуудлаар ажиллагсдын зөвлөлтэй хамтран ажиллах арга хэлбэрийг бий болгосон байна.

32.4. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх механизмд ажиллагсдын оролцоог хангана. Үүнд:

32.4.1. ТУЗ-д ажиллагсдын төлөөллийг оруулдаг байх нөхцлийг бүрдүүлнэ.

32.4.2. Компанийн зарим нэг чухал шийдвэрт ажиллагсдын санаа бодлыг тусгах зорилгоор ажилчдын зөвлөлөөр дамжуулан санал авдаг байх нөхцлийг бүрдүүлнэ.

32.4.3. Компанийн үр ашгийг дээшүүлэхэд ажиллагсдын идэвхитэй оролцоог хангах явдал чухал бөгөөд үүнд ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр болон бусад хэлбэрийн ашиг хуваах зэрэг арга аргачлал байж болно.

32.4.4. Тэтгэвэрийн гэрээ нь компаниас одоогийн болон өмнө ажиллаж байсан ажиллагсадтай харилцах чухал элемент болдог тул компани тэтгэврийн тусгай сан байгуулсан нөхцөлд тухайн сангийн итгэмжлэгдсэн удирдлага нь компанийн удирдлагаас хараат бус байх бөгөөд тэтгэвэр авагчдын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг байна.

32.5. Сонирхогч талууд болон ажиллагсдын оролцоог хангах нь тэдний төлөөллийн байгууллага нь компанийн хэмжээнд гарч буй хууль бус эсвэл ёс зүйгүй үйлдлийн талаар ТУЗ-д чөлөөтэй мэдээлэх, санал бодлоо илэрхийлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Үүнд:

32.5.1. Хууль бус, ёс зүйгүй үйл ажиллагаатай холбогдуулан ажиллагсдаас биечлэн, эсвэл өөрсдийн төлөөллийн байгууллагаар дамжуулан эсвэл тухайн компанид ажилладаггүй хэн нэгнээр дамжуулан гаргасан гомдлыг хянан авч үзэх тодорхой дүрэм журамтай байна.

32.5.2. ТУЗ нь хараат бус гишүүн, аудитын хорооны гишүүн эсвэл нэр дэвшүүлэх хорооны гишүүнтэй гомдол гаргагчийг уулзах боломжийг хангасан байна.

32.5.3. Хууль зөрчсөн талаар гаргасан гомдлын мөрөөр ямар нэг арга хэмжээ аваагүй тохиолдолд тухайн гомдлыг төрийн зохих байгууллагад гаргадаг байна.

32.5.4. Төрийн зохих эрх мэдэл бүхий байгууллагад гомдол гаргасан ажиллагсдын хувьд компани ямар нэг ялгаварлан гадуурхах эсвэл сахилгын арга хэмжээ авч болохгүй.

32.6. Компани нь хэрэглэгчдийн эрх ашгийг болон хүрээлэн буй орчныг хамгаалах болон компанийн нийгмийн хариуцлагын үүргээ зохих түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай. Компанийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөө өсөхийн хирээр нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага нь нэмэгдэх бөгөөд цаашдын үйл ажиллагаанд нь хэрэглэгчид болон олон нийтийн оролцоо нэмэгдэх учраас эдгээр нь чухал оролцогч тал болдог.

32.7. Хэрвээ оролцогч тал нь компанийн хувьцаа эзэмшигч бол оролцогч талын болон хувьцаа эзэмшигчийн эрх нь тус бүрдээ хамгаалагдсан байх ба эрхээ хэрэгжүүлэхийг шаардана. Хувьцаа эзэмшигчийн хувьд эдлэх эрх нь оролцогч талын эрхээр хязгаарлагдахгүй, давхар оролцогч тал болсон нөхцөлд хувьцаа эзэмшигчийн хувьд зөвхөн компанийн ашгаас хүртэх эрхийг зорилгоо болгож болохгүй.

32.8. Компани оролцогч талын эрхийг зөрчсөн тохиолдолд хохирлыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авах бөгөөд оролцогч талууд хуулийн дагуу эрх ашгаа хамгаалуулах арга хэмжээг авах нь зүйтэй. Хэрвээ компани нь холбогдох хууль журамд болон оролцогч талуудтай байгуулсан гэрээнд заасан эрхийг зөрчвөл алдаагаа засаж, нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээг яаралтай авах бөгөөд эрх нь зөрчигдсэн оролцогч талууд хохирлоо барагдуулах үр ашигтай механизмыг ашиглах ёстой.

33 дугаар зүйл. Оролцогч талуудын хяналт

Компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, оролцогч талуудын ашиг сонирхол, хууль ёсны эрхийг хамгаалахын тулд компанийн үйл ажиллагаан дахь хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байна.

33.1. Компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу компанийн үйл ажиллагааг явуулдаг, тэдгээрт үндэслэн компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих бодитой хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байна.

33.2. Компани нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж буй гүйцэтгэх удирдлага, түүний гишүүд, компанийн ажилтан албан хаагчдын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоог гүйцэтгэх удирдлагаас хараат бус хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг, хяналтын үйл ажиллагааны дүнгээ ТУЗ-д тайлагнадаг, тэдгээрийн үйл ажиллагааны журмыг ТУЗ тогтоодог байна;

33.3. Компани нь дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцооны уялдаа холбоог зохистой хэлбэрээр хангаж ажиллана. Үүний тулд дараах зохицуулалтыг хэвшүүлсэн байна:

33.3.1. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь компанид хөндлөнгийн хяналт хийх этгээдийн үйл ажиллагааг үнэлдэг, тэдгээрийг сонгохдоо мэргэшил, ажлын дадлага туршлагыг харгалздаг байна;

33.3.2. Хөндлөнгийн хяналтын байгууллагын зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаад ТУЗ-ийн аудитын хороо хяналт тавьдаг байна;

33.3.3. Хөндлөнгийн аудитын байгууллага буюу аудиторыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулдаг, хувьцаа эзэмшигчид тэдэнд хандан асуулт тавих, тайлбар авах боломжийг бүрдүүлсэн байна.

33.4. Компанийн удирдлагын үйл ажиллагаанд оролцогч талууд мониторинг хийх боломжтой байна.

33.4.1. Компанийн удирдлагын үйл ажиллагаанд оролцогч талууд мониторинг хийх хэлбэр, хэмжээг компани тус бүр өөрийн онцлогийг тусган тодорхойлох ёстой. Ингэхдээ оролцогч талуудын онцлог шинж чанар, тэдгээр нь компанийн үйл ажиллагаанд мониторинг хийх хүсэлтэй эсэхийг харгалзан үзэх шаардлагатай. Оролцогч талууд нь эрхээ хамгаалахын тулд шаардлагатай мэдээллийг олж авах боломжтой байх ёстой.

33.4.2. Зээлдүүлэгчдийн зүгээс компанийн үйл ажиллагаанд мониторинг хийхдээ тухайн компанийн онцлогийг харгалзан үзэх ёстой. Зээлдүүлэгчид компанийн удирдлагын үйл ажиллагаанд оролцохдоо компанийн онцлогийг харгалзан үзэх бөгөөд талуудын хооронд байгуулсан гэрээнд зээлдүүлэгчийг ямар мэдээллээр хэрхэн хангаж байх талаар заасан байна.

33.4.3. Компанийн ажилтнууд компанийн засаглалын үйл ажиллагаанд оролцох хэлбэр, хир хэмжээ нь компанийн тогтвортой хөгжлийг хангахад тус дөхөм болохуйц байх ёстой.

Компани ажилтнуудын хурлыг тогтмол зохион байгуулдаг, хурал дээр компанийн бизнес төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхийн тулд авах арга хэмжээ, өмнөх бизнес төлөвлөгөөний биелэлтийн тайлан, улирлын үйлдвэрлэлийн төлөвлөгөө, хүний нөөцөө хөгжүүлэх төлөвлөгөө болон компанийн санхүүгийн байдлын талаар танилцуулж, ажиллагсдын сонирхсон асуултад хариулдаг байх ёстой. Компани ажилтнуудтайгаа нягт хамтран ажиллаж, тэдний санал бодлыг удирдлагын үйл ажиллагаанд тусгадаг байх нь үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлж, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх нэг хүчин зүйл болно.

33.4.4. Ажилтнууд компанийн удирдлагад оролцох боломжийг нэмэгдүүлэхийн тулд компанийн ашгаас хүртэх механизм буюу ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг дэмжинэ. Ажилтнууд компанийнхаа хувьцааг эзэмшсэнээр ажилдаа хандах хандлага өөрчлөгдөж, ажил олгогч болон ажилтнуудын хамтын ажиллагаа сайжирна. Үүнээс гадна компанийн үйл ажиллагаа болон хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах тал дээр мониторинг хийхэд идэвхтэй оролцох болно.

Ажилтнууд нь эрхээ хамгаалахад шаардагдах мэдээллийг олж авах эрхтэй. Компанийн цалин урамшууллын бодлого, бизнес төлөвлөгөөний тайлбар, тухайн улирлын төлөвлөгөө, хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө болон санхүүгийн байдлын талаарх ерөнхий мэдээллийг тогтмол өгдөг байх ёстой.

33.4.5. Компани нь оролцогч талууд эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай холбогдох хууль тогтоомжид заасан мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

Зээлдүүлэгчдэд эрсдэлээ үнэлэх, зээлийн багцаа удирдахад шаардагдах мэдээллээр хангах нөхцөлийг зээлдүүлэгчтэй байгуулах гэрээнд тодорхой зааж өгөх бөгөөд уг гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлж, давуу эрх бүхий зээлдүүлэгчидтэй байгуулсан гэрээ зэрэг зээлдүүлэгчид нөлөөлөх асуудлын талаар мэдээлж байх шаардлагатай.

Нөгөө талаас зээлдүүлэгч, ажилтнууд зэрэг оролцогч талуудад өгөх мэдээлэлд тодорхой хязгаарлалтыг тогтоох ёстой ба энэ нь компанийн нууц буюу дотоод мэдээллийг ашиглан сөрөг үйлдэл хийхээс сэргийлнэ. Иймд зөвхөн холбогдох хууль журамд заасан мэдээллийг оролцогч талуудад өгөх үүрэг хүлээнэ. Оролцогч талууд компаниас авсан мэдээллээ хувьдаа ашиглахыг хориглоно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ХЯНАЛТ

34 дүгээр зүйл. Үндсэн ойлголт

Компанийн хяналтын тогтолцоо нь хөрөнгө оруулагчдын зүгээс компани болон түүний удирдлагад итгэх итгэлийг бий болгох, бэхжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн компанид оруулсан хөрөнгө оруулалт, түүний өөрийн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хадгалан хамгаалах зорилготой байна.

Компанийн хяналтын тогтолцоог бүтцийн хувьд дотоод хяналт ба хөндлөнгийн хяналт гэж ангилна. Компанийн дотоод хяналтын тогтолцоонд түүний бүтцийг ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо мөн дотоод аудитын албатай байхаар бүрдүүлэх нь зүйтэй. Харин хөндлөнгийн хяналтын тогтолцоонд компаниас хараат бус мэргэжлийн аудитын байгууллага /аудитор/-ыг ойлгоно.

ТУЗ-ийн дэргэд ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх аудитын хороо болон дотоод аудитын албыг байгуулан тэдгээрийн эрх, үүргийг нарийвчлан зохицуулж холбогдох дүрэмд тусган хэрэгжүүлэх замаар компанийн үйл ажиллагааны хяналтыг явуулах нь зүйтэй.

35 дугаар зүйл. Компанийн хяналтын үндсэн шаардлага

35.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дээр дурдсан үндсэн зорилгыг хангаж ажиллахын тулд дараах үндсэн зарчмыг хангах шаардлагатай байдаг. Үүнд:

35.1.1. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг тодорхой төлөвлөгөөнд үндэслэн гүйцэтгэдэг, хяналтыг түүнд үндэслэн гүйцэтгэж, хяналт нь компанийн үйл ажиллагаанд үнэлэлт өгдөг байна.

35.1.2. Хяналтын тогтолцоо нь компанийн өдөр тутмын ажиллагаанаас эхлэн жилийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт зэрэг бүх шат, хүрээний үйл ажиллагааг бүрэн хамарсан байна.

35.1.3. Хяналтын тогтолцоо нь чадварлаг, шуурхай, мэргэшсэн, хараат бус, компанийн зохистой ажиллагаа, үр ашгийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, түүнийг эрсдэлээс сэргийлж чаддаг байна.

35.1.4. Хяналтын тогтолцоо нь бүтцийн хувьд харилцан нягт уялдаатай холбоотой, үйл ажиллагаа нь ил тод, үйл ажиллагааны журам, хуваарь, эрх хэмжээ нь компанийн дүрэм, хяналтын журамд тодорхой туссан, ойлгомжтой байна.

35.1.5. Хяналтын тогтолцоо нь компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын хууль бус, зохисгүй аливаа ажиллагааг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадвар бүхий байна.

35.1.6. Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийн шинжилгээг тогтмол хийж, түүнээс урьдчилан сэргийлж ажилладаг, компанийн удирдлагад эрсдэлээс сэргийлэх талаар дэмжлэг үзүүлж ажилладаг байна.

35.1.7. Компаниас нийтийн хүртээл болгож байгаа болон удирдлагын шийдвэр гаргах үндэслэл болж байгаа санхүүгийн болон бусад мэдээ, мэдээллийн үнэн зөв байдалд мөн хяналт тавьдаг байна.

35.1.8. Шалгалтын явцад илрүүлсэн, эсхүл танилцсан аливаа нууц болон дотоод мэдээлэлд хамаарах мэдээллийг хяналтын тогтолцоонд хамаарах нэгж, албан тушаалтан бусдад задруулах, буруугаар ашиглах эрхийг хязгаарласан, хүлээх хариуцлага нь тодорхой байна.

36 дугаар зүйл. Компанийн дотоод хяналт

36.1. Компанийн дотоод хяналт нь компанийн бүхий л ажиллагсдын чиг үүрэгтэй холбоотой учраас ажилтан, ажилчин бүрийн ажлын байрны тодорхойлолтод тэдгээрийн хяналтын чиг үүргийг тодорхойлон заасан байх ёстой.

36.2. Компанийн дотоод хяналтын тогтолцоонд ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооноос /цаашид "АХ" гэх/ санал болгон ТУЗ-өөс томилогдож түүнд тайлагнадаг Дотоод аудитын алба /цаашид "ДАА" гэх/ чухал үүрэгтэй байна.

36.3. Хяналтын тогтолцоонд хамаарах нэгжүүд нь харилцан дэмжлэг үзүүлэхээс гадна аливаа хяналтын үр дүнгийн талаар тухай бүр харилцан мэдээлдэг байх нь зүйтэй. Ялангуяа, ДАА нь ТУЗ-ын дэргэдэх аудитын хороо чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа мэдээ мэдээллийг үнэн зөвөөр, шуурхай гаргаж өгөхөд дэмжлэг үзүүлж ажиллана.

36.4. АХ, ДАА-ны үйл ажиллагааны журмыг тусгайлан боловсруулж, ТУЗ батлан мөрдүүлдэг байх ёстой. Энэ нь тэдгээрийг чиг үүргээ хэрэгжүүлэх баталгааг бий болгохоос гадна үйл ажиллагааг нь дүгнэх, чиг үүргийн давхардлыг арилгах, үйл ажиллагааны уялдаа холбоог нь хангах, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд ач холбогдолтой.

36.5. АХ-г ТУЗ-ийн гишүүдээр бүрдүүлж, гишүүдийн тоог нь 3-аас багагүй байхаар, гишүүдийнх нь дийлэнх олонх нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байхаар, ялангуяа АХ-ны дарга нь заавал хараат бус гишүүн байхаар компанийн дүрэмд зааж, АХ-ны гишүүдийг ТУЗ-ийн хурлаас сонгодог байна.

36.6. АХ нь компанийн үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх, төлөвлөгөөний биелэлт ямар байгаа, компанийн санхүүгийн удирдлага зохистой байгаа эсэх, компани нь санхүү, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтөлж байгаа эсэх, компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх, нууц болон дотоод мэдээлэл алдагдсан эсэх, түүнийг буруугаар ашигласан эсэх, хөндлөнгийн аудитыг зохих ёсоор

гүйцэтгэсэн эсэх, ДАА-ны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх чиглэлээр тогтмол хяналтыг хэрэгжүүлдэг хараат бус нэгж байна.

36.7. АХ нь компанийн үйл ажиллагааны явцад хийсэн хяналтын дүнг хурлаараа заавал хэлэлцэх бөгөөд гишүүдийн олонх нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эрх зүйн боловсролтой, мэргэжлээрээ нарийн мэргэшсэн зүйтэй.

36.8. АХ нь шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ХЭХ-ыг зарлан хуралдуулах, түүгээр хэлэлцэх асуудлыг санал болгох, ДАА-ны үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, ДАА-ны хараат бус үйл ажиллагаанд хяналт тавих, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах, зөрчил гаргасан бол түүнийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх удирдлагын бүрэн **эрхийг түдгэлзүүлэх талаар ТУЗ-д санал оруулах эрхтэй**.

36.9. АХ нь хөндлөнгийн аудитын үйл ажиллагаа зохих журмын дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавихаас гадна хөндлөнгийн аудиторoor ажиллахаар нэр дэвшигчдийн талаар урьдчилан хэлэлцэж, ТУЗ-д оруулахаас гадна түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийн талаар санал гаргах эрхтэй байна.

36.10. АХ-ны үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангахад шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримтыг гүйцэтгэх удирдлага, түүнд хамаарах нэгжүүд, эрх бүхий албан тушаалтан саадгүй гаргаж өгөх үүрэгтэй байхаас гадна холбогдох мэдээллийг гаргаж өгөөгүй нөхцөлд хэрхэн шийдвэрлэх талаар **холбогдох** дүрэмд тусгасан байна.

36.11. ДАА-ны үйл ажиллагааны зарчим, журмыг АХ-ны санал, дүгнэлтэд үндэслэн гаргана. ДАА нь **хяналт шалгалт явуулах талаар хүсэлт, гомдол шийдвэрлэхдээ холбогдох журам эсвэл дүрмийн дагуу шийдвэрлэнэ**.

36.12. ДАА-ны зорилго нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, нөхцөл шаардлагын дагуу хийгдсэн эсэх, холбогдох эрх бүхий ажилтан үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн эсэх, төсвийн зарцуулалт, компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын ажиллагаанд аливаа алдаа, дутагдал гарч буй эсэхэд хяналт тавихаас гадна АХ-ны ажиллагаанд дэмжлэг үзүүлж, тэдгээрт болон гүйцэтгэх удирдлагад шаардлагатай заавар, зөвлөмжийг хүргэж ажиллана.

36.13. ДАА нь шалгалтын дүнгээ тухай бүр АХ-д хүргүүлэхээс гадна шийдвэрийн биелэлтээ гүйцэтгэх удирдлага болон АХ-д тайлагнадаг байна.

36.14. Холбогдох төлөвлөгөөнд тусаагүй, их хэмжээний хэлцэл, эсхүл сонирхлын зөрчил бүхий хэлцэл хамаарах магадлал бүхий, эсхүл компанийн өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд байнга гүйцэтгэдэггүй гэрээ, хэлцэл, ажиллагаатай холбоотой асуудлыг гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтанд ДАА-аар заавал, шаардлагатай гэж үзвэл АХ-р хянуулдаг байна. Үүнтэй холбоотой харилцааг дүрмээр нарийвчлан зохицуулсан байвал зохино.

36.15. АХ-ны хурлын явцад тэмдэглэл хөтөлж, тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн талаар тодорхой бичсэн байна. АХ нь хяналт шалгалтын үр дүнг тодорхой тусгасан тайланг жил бүр ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

36.16. Хувьцаа эзэмшигчид АХ, ДАА-ны хурлын тэмдэглэл, шалгалтын тайлан, дүгнэлттэй саадгүй танилцах эрхтэй байна.

36.17. АХ, ДАА нь хөндлөнгийн аудитор, эсхүл хөндлөнгийн шинжээч / нягтлан бодогч ба хуульч зэрэг/-ээс шаардлагатай туслалцаа, зөвлөгөөг авч болно.

36.18. АХ, ДАА нь өөрсдийн гишүүд, ажилтны танилцуулга, намтар болон үйл ажиллагааныхаа жилийн тайланг тухайн жилд багтаан гаргаж дараа жилийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулдаг байна.

37 дугаар зүйл. Хөндлөнгийн аудитын хяналт

37.1. Хөндлөнгийн аудитын байгууллага /аудитор/ нь аудитын ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд, холбогдох дүрэм журам, стандартын дагуу, хараат бусаар, хэн нэгний нөлөөнд авталгүйгээр, бодитой эрхлэн явуулна. Аудитор нь компанийн үйл ажиллагаа явуулж байгаа

салбарын онцлогийг сайн мэддэг байвал зохино. Аудитор нь тухайн компанийн нягтлан бодох бүртгэлийг хөтөлдөг, компанид удирдлагын болон татварын асуудлаар зөвлөгөө өгдөг бол түүнийг хараат бус гэж үзэхгүй.

37.2. Дээрх нөхцөл, байдалд харшлах зүйл бүхий аудиторыг сонгох боломжийг хаасан байна. Энэ талаар аудитортой байгуулах гэрээнд нарийвчлан тусгаж хяналтыг хэрэгжүүлдэг байна.

37.3. Хөндлөнгийн аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн дүрмийг чанд баримтлах бөгөөд компанийн удирдлагын болон хяналтын багц эзэмшигчдийн зүгээс санал болгосон, тэдгээрийн хувийн сонирхлыг тусгасан гэрээ байгуулахыг хориглоно.

37.4. Хөндлөнгийн аудиторууд нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож аудитын шалгалтын тайлантай холбоотой хувьцаа эзэмшигчдийн асуултад хариу өгдөг байна.

37.5. Хөндлөнгийн аудиторуудын санаатай, санамсаргүй алдааны улмаас аудитын шалгалтын тайланг ашиглагч этгээдэд хохирол учирвал хөндлөнгийн аудитор нь учирсан хохирлыг барагдуулах үүрэг хүлээдэг, хүлээх хариуцлагын талаар тэдгээртэй байгуулах гэрээнд тодорхой тусгасан байна.

37.6. Нийтэд хүргэсэн мэдээлэл нь санхүүгийн тайланд тусгагдсан мэдээллээс зөрүүтэй байгаа нь шалгалт хийх явцад тогтоогдвол аудиторууд уг мэдээллээ залруулахыг шаардах эрхтэй бөгөөд залруулах үүргийг компанийн гүйцэтгэх удирдлага хүлээнэ.

37.7. Хөндлөнгийн аудиторууд нь шалгалтын явцад илэрсэн компани, түүний гүйцэтгэх удирдлагыг гаргасан зөрчлийг нуун дарагдуулалгүйгээр ТУЗ, ХЭХ-д мэдээлдэг байна.

37.8. Хөндлөнгийн аудиторын дүгнэлтэд тухайн компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадвартай эсэх талаар тухайлан заасан байна. Хөндлөнгийн аудиторууд нь шалгаж буй компанийнхаа төлбөрийн чадварын талаар онцлон дүгнэлт гаргах ёстой бөгөөд энэ асуудал нь ихээхэн ноцтой үр дагавартай байдаг учраас хариуцлагатай хандан, онцгой анхаарал хандуулах ёстой. Хөндлөнгийн аудиторууд нь компанийн төлбөрийн чадварын талаар дүгнэлт гаргахаас зайлсхийх, хариуцлага хүлээхгүйн тулд тодорхой бус, хоёрдмол санаатай, ерөнхий дүгнэлт гаргах ёсгүй.

Аудитын дүгнэлт нь компанийн санхүүгийн тайлан үнэн зөв болохыг нотлохын хамт тухайн тайланг хэрхэн бэлтгэж боловсруулсан талаарх аудиторын саналыг тусган оруулна. Мөн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн тохиолдолд уг хэлцэл нь хуульд заасан журмын дагуу хийсэн эсэх асуудлаар дүгнэж оруулсан байна. Энэ нь компанийн хяналт шалгалтын орчинг сайжруулахад ач холбогдолтой байх болно.

37.9. Хөндлөнгийн аудитын үйлчилгээний хөлсийг зөрчил илрүүлснээс хамаарч багасгах, эсхүл гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны талаар эерэг дүгнэлт гаргаснаас хамаарч ихэсгэдэг байж болохгүй.

37.10. Хөндлөнгийн аудиторууд нь хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээх ба аудитыг мэргэжлийн зохих түвшинд хийх үүрэг хүлээнэ.

Хөндлөнгийн аудитор нь үүргээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд компанийн ашиг сонирхлын үүднээс гүйцэтгэхээс биш ажил төрлийн шаардлагаар харилцаж байгаа аль нэг удирдлагын бүлэг эсвэл компанийн удирдлагын эрх ашгийн үүднээс асуудалд хандахгүй.

37.11. Аудитын компани нь өөрийн үйлчлүүлэгч компанид аудитын бус үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

37.12. Дүн шинжилгээ хийж буй шинжээч, брокер, түвшин тогтоодог агентлагууд дүгнэлт гаргахад ямар нэгэн байдлаар ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх зохих тогтолцоог бий болгосон байна.

37.12.1. Зөвлөмжийг өгч байгаа зөвлөх нь тухайн компанид бас өөр үйлчилгээ үзүүлдэггүй байх болон тухайн компанид эсвэл түүний өрсөлдөгч компанийн хувьд ашиг сонирхлын зөрчилгүй байх шаардлагыг тавьж түүний хариуцлагыг тодорхойлсон зохицуулалтыг гаргасан байна.

37.12.2. Хөрөнгийн зах зээлийн судлаачид болон зэрэглэл тогтоох агентлагууд, хөрөнгө оруулалтын банк зэрэг байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангасан байна.

Үнэт цаасны хорооны олон улсын байгууллагаас /IOSCO/ шинжээчид болон зэрэглэл тогтоодог агентлагуудын баримтлах зарчмуудыг тусгасан мэдэгдлүүдийг гаргасан бөгөөд үүнийг гарын авлага хэлбэрээр ашиглаж болно. /Үнэт цаас арилжаалдаг байгууллагуудын

НАЙМДУГААР БҮЛЭГ. НОГДОЛ АШИГ

38 дугаар зүйл. Ногдол ашгийн бодлого

38.1. Ногдол ашгийн бодлого, ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилах арга, механизм нь тодорхой, ойлгомжтой байх ёстой.

38.1.1. Хувьцаат компанийн хөрөнгө оруулалт татах чадвар нь түүний ногдол ашиг хуваарилалт, ногдол ашгийн бодлоготой шууд холбоотой байдаг. Компанийн хувьцааг худалдан авч, хөрөнгө оруулалт хийхдээ тодорхой хэмжээний орлого олохоор төлөвлөдөг. Ийм учраас “Ногдол ашгийн бодлого”-ыг ТУЗ-өөс боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлан мөрдүүлэх нь зүйтэй. Уг бодлого нь тухай үе дэх хувьцаа эзэмшигчид болон ирээдүйн хөрөнгө оруулагчдад компанийн ашиг хуваарилалтын бодлого, хэмжээ, хуваарилах арга хэлбэрийн талаар тодорхой тусгасан байвал зохино;

38.1.2. ТУЗ нь “Ногдол ашгийн бодлого”-ыг нийтэд мэдээлэхээс гадна түүнтэй компанийн вэб хуудас болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлсэн байна;

39 дүгээр зүйл. Ногдол ашиг хуваарилах

39.1. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлэх ёстой бөгөөд уг мэдээлэл нь ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн ойлголт өгөхүйц байх ёстой.

Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг болдог учраас энэ шийдвэр нь компанийн бодит байдлыг зөв тусгасан байх ёстой. Өөрөөр хэлбэл хуваарилж байгаа ногдол ашгийн хэмжээ нь компанийн бодит боломжоос хэтэрхий дээгүүр, эсхүл хэтэрхий доогуур байж болохгүй. Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байх нь зүйтэй.

39.2. Компани ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг ТУЗ хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар заавал танилцуулан хэлэлцүүлдэг байх шаардлагатай. Ялангуяа, ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө заавал танилцуулдаг байна.

39.3. Хэдийгээр ногдол ашгийг үнэт цаас, биет эд хөрөнгөөр олгож болох ч ногдол ашгийг мөнгөн хөрөнгөөр олгодог байх нь зохимжтой. Энэ нь ногдол ашгийг тогтоосон хугацаанд олгосон эсэхэд хяналт тавих, ногдол ашиг олгох ажиллагааг аливаа маргаан, чирэгдэл, будлиангүйгээр зохион байгуулахад ач холбогдолтой.

39.4. Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна. Ногдол ашгийн хуваарилах хэлбэр, аргыг сонгохдоо хувьцаа эзэмшигчдийн оршин суугаа газар, ногдол ашгийг шуурхай хүлээн авах боломжийг харгалзана. Хувьцаа эзэмшигчид хүлээн зөвшөөрсөн, эсхүл компанийн оршин байх газраас өөр газар оршин суудаг бол ногдол ашгийг түүний банканд дахь дансанд, эсхүл гуйвуулгаар, эсхүл түүний үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар олгох нь зүйтэй.

39.5. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацааг тодорхой зааж, тогтоосон хугацаандаа бүрэн олгож дуусдаг байна. Ногдол ашиг хуваарилах хугацаа нь 60 хоногоос ихгүй байвал зохимжтой.

39.6. Ногдол ашгийг хугацаанд нь бүрэн олгоогүйгээс хувьцаа эзэмшигчдэд чирэгдэл учруулсан, хохироосон гүйцэтгэх удирдлагын ажилтанд хариуцлага хүлээлгэх журмыг тусгайлан компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээ, бусад дотоод журмуудад тусгасан байна. Ногдол ашгийг тогтоосон хугацаанд хуваарилах ажлыг хариуцлагагүй зохион байгуулсан тохиолдолд гүйцэтгэх удирдлагын урамшууллаас хасдаг, түүнд эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэдэг байж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. КОМПАНИ ДАХЬ ЗӨРЧЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

40 дүгээр зүйл. Үндсэн ойлголт

Компанийн удирдлага ба хувьцаа эзэмшигчдийн хооронд, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хооронд бий болсон зөрчил нь компанийн эрх ашигт нөлөөлж байвал уг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, эсхүл сонирхлын зөрчил бий болсон тохиолдолд зохицуулах чадвартай байх нь компани хэвийн үйл ажиллагааг хангах, тавьсан зорилгодоо хүрэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг зохицуулах боломжтой байх нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг болон компанийн өмч, нэр хүндийг хамгаална.

Сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бий болсон нөхцөлд зохицуулах үр ашигтай механизм байх нь сонирхлын зөрчлийг бий болохоос өмнө илрүүлж шийдвэрлэх, сонирхол нь зөрчилдөж байгаа этгээдүүд асуудлаа шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.

Компанийн удирдах байгууллага бүр нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудалтай холбогдон үүссэн үл ойлголцол, маргааныг шийдвэрлэх арга хэмжээг шуурхай авдаг байна.

41 дүгээр зүйл. Маргаан шийдвэрлэх

41.1. Компанийн хувьцаа эзэмшигчид болон удирдлагын хооронд үүссэн аливаа үл ойлголцол ба маргаан (энэхүү кодекс болон компанийн дотоод баримт бичгийг мөрдөхтэй холбоотой г.м) эсхүл компанийн хувьцаа эзэмшигчдийн хооронд үүссэн үл ойлголцол ба маргаан нь компанийн ашиг сонирхолд нөлөөлж байвал үүнийг компанитай холбоотой зөрчил гэж үзнэ. Иймд эдгээр зөрчлийг аль болох эрт илрүүлэн зохицуулахад компанийн эрх бүхий албан тушаалтнууд онцгой анхаарал хандуулах ёстой.

41.2. Компанитай холбогдох аливаа зөрчил маргааны талаарх мэдээллийг хүлээн авч, бүртгэх нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг байна. Тэрээр хувьцаа эзэмшигчдээс ирүүлж буй захидал, шаардлагыг хүлээн авч бүртгэн, тухайн маргаан зөрчлийг шийдвэрлэх эрх бүхий этгээдэд шилжүүлнэ. Компанийн салбар, төлөөлөгчийн газрын тухайд удирдлага нь хүлээн авч, компанийн нарийн бичгийн даргад үүссэн зөрчил маргааны талаарх бүрэн мэдээллийг дамжуулна.

41.3. Зөрчил үүссэн нөхцөлд гүйцэтгэх албан тушаалтан эсхүл ТУЗ аль болох богино хугацаанд уг асуудалтай холбоотой мэдээ, мэдээлэл, баримтыг үнэн зөвөөр гаргаж өгөх, үйл явдлыг тайлбарлаж, хууль тогтоомж, дүрэм журамтай хэрхэн нийцэж буй, эсхүл зөрчилдөж буй талаар зөвлөгөө өгч, байр сууриа илэрхийлэн, холбогдох шийдвэрийг хуульд нийцүүлэн гаргаж, сонирхогч этгээдэд мэдэгдэх ёстой. Зөрчлийг шийдвэрлэх талаар гаргасан шийдвэрээр зөрчилдөж байгаа талуудад хүргэхдээ шийдвэрийнхээ үндэслэлийг ойлгомжтой хэлбэрээр тайлбарласан байх нь дахин асуудал үүсэхгүй эцэслэн шийдвэрлэхэд чухал ач холбогдолтойг анхаарах ёстой.

41.4. Зөрчлийг бодитойгоор үнэлэхийн тулд сонирхол нь зөрчилдөж байгаа буюу зөрчилдөх магадлал бүхий талуудыг оролцуулалгүйгээр асуудлыг шийдвэрлэх үр ашигтай зохицуулалтыг бий болгох ёстой.

41.5. Компанийн болон бусад хувьцаа эзэмшигчдийн сонирхолд нөлөөлж болохуйц сонирхлын зөрчил тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хооронд бий болсон нөхцөлд зөрчлийг авч үзэх үүрэгтэй компанийн эрх бүхий этгээд нь энэхүү маргааныг өөрийн түвшинд шийдвэрлэх боломжтой эсэх болон компанийн эрх ашигт нөлөөлөх эсэх зэрэг асуудлуудыг харгалзан үзэх ба түүнчлэн зөрчлийг зохицуулахад шаардагдах бүх арга хэмжээг авах ёстой.

41.6. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлаар шийдвэр гаргахад оролцох аль нэг этгээд нь сонирхогч этгээд байгаа бол шийдвэр гаргахаар асуудлыг хэлэлцэхээс өмнө энэ тухайгаа мэдэгддэг, шийдвэр гаргахад оролцдоггүй байх журмыг мөрдлөг болгох ёстой. Хэрвээ энэ талаар мэдээлэл өгөлгүй шийдвэр гаргахад нөлөөлсөн нь хожим илэрсэн тохиолдолд хүлээх хариуцлага нь тодорхой байх ёстой. Шийдвэрт үзүүлсэн нөлөө нь компани болон хувьцаа эзэмшигчдэд ноцтой хохирол учруулсан, ийм зөрчил давтагдсан тохиолдолд эрх бүхий албан тушаалаас эргүүлэн татдаг байх ёстой. ТУЗ-ийн гишүүн ийм зөрчил гаргасан бол хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх ёстой.

41.7. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг “Компанийн тухай” хуульд заасан журмын дагуу хийж, тайлангийн жилд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар зохицуулах байгууллагаас тогтоосон журмын дагуу мэдээлдэг байх ёстой.